

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР / ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1	Хуралдааны товч тэмдэглэл:	1-29
2	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	30-116
	1.Хуулийн төсөл эцэслэн батална	33-35
	2.Генетик нөөцийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2019.10.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	35-36
	3.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай”Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Генетик нөөцийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	36-38
	4.Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.30-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	38-54
	5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	55-63
	6.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	63-65
	7.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	65-66
	8.Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	66
	9.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2021.05.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	67-77
	10.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.10.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	77-85
	11.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /Засгийн газар 2021.10.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	85-87
	12.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С,Бямбацогт нарын 15 гишүүн 2021.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	87-116

Хураангуй тэмдэглэл

Арван хоёр. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүн 2021.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор О.Мөнхсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Золбоо нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Х.Болорчулуун, Ш.Раднаасэд, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Сүхбаатар нар хариулж, тайлбар хийв.

Нэг.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

1.1.Чуулганы нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөнтэй холбоотой саналын томьёолол:

Г.Занданшатар: 1.Төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.4.Энэ хуулийн 22.2-т заасан дүн шинжилгээ, 22.3-т заасан дүгнэлтийг харгалзан шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал нэг дэх хэлэлцүүлгээс төсвийн төслийг Үндсэн хууль, холбогдох хуульд нийцүүлэх чиглэл өгч зөвхөн нэг удаа Засгийн газарт буцаана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	19
Бүгд:	40

52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 29 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсгол

29.1.Эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас дараах нэр дэвшигчийн сонсгол явуулна:

29.1.1.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Авилгатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Ерөнхий аудитор, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, Үндэсний статистикийн хорооны дарга, Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргын албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсгол;

29.1.2.Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол явуулахаар хуульд тусгайлан заасан, эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.

29.2.Нэр дэвшигчийн сонсгол нь баримт, мэдээлэлд үндэслэсэн, талуудын оролцоог тэнцвэртэй хангасан байх бөгөөд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуульд заасан бусад шаардлага хангасан эсэхийг нээлттэй хэлэлцэж, олон нийт нэр дэвшигчийн талаар мэдэх эрхийг хангахад чиглэнэ.

29.3.Нэр дэвшигчийн сонголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ явуулна.

29.4.Нэр дэвшигчийн сонгол явуулахад энэ хууль, Нийтийн сонголын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

29.5.Байнгын хорооноос нэр дэвшигчийн сонгол /цаашид энэ бүлэгт “сонгол” гэх/ явуулах үйл ажиллагаанд Тамгын газар мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

29.6.Нэр дэвшигчийн дэлгэрэнгүй танилцуулга, томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, тухайн албан тушаалд тавих нийтлэг болон тусгай шаардлага зэрэг мэдээллийг авах маягтын загварыг холбогдох Байнгын хороо батална.

29.7.Энэ хуулийн 29.6-д заасан загварт дурдсан мэдээллийг нэр дэвшигчээс өөрөөс нь гаргуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	16
Бүгд:	40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.2.Сонголд холбогдох Байнгын хорооны гишүүдээс гадна Нийтийн сонголын тухай хуулийн 10.2-т заасан оролцогчид оролцох бөгөөд тус хуулийн 15 дугаар зүйлд заасан нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	17
Бүгд:	40

57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.1.Түр хороо 5-19 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Улсын Их Хурлын гишүүн нэгэн зэрэг хоёроос илүүгүй түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	20
Татгалзсан:	19
Бүгд:	39

51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсгийг хасаж, төслийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
51.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 5.Төслийн 36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсгийг хасаж, төслийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 37 дугаар зүйлийн 37.2, 37.3, 37.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.2.Түр хорооны гишүүн гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах тухай тогтоолын төсөл санаачилсан бол тухайн асуудлыг түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Санал хураалтаар цөөнх болсон гишүүн тухайн асуудлаар үндэслэлээ дэлгэрэнгүй тайлбарлаж, гурав хүртэл удаа санал хураалгаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.5 дахь хэсэг нэмэх:

“17.5.Улсын Их Хурал энэ хуулийн 17.4-т заасан тогтоол баталсан бол тухайн тогтоолд заасан хугацаанд Засгийн газар тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.7 дахь хэсэг нэмэх:

“19.7.Улсын Их Хурал энэ хуулийн 19.2, 19.6-д заасан тайланг хянан хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт холбогдох чиглэл өгөх тогтоол батална. Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнг тухайн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсгийг хасаж, дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 33 дугаар зүйлийн 33.11 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй 11 дэх санал дэмжигдсэн тул доорх саналаар санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хасаж, төслийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг уншиж танилуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:21/

1.2. Зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбоотой найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.5, 19 дүгээр зүйлийн 19.5, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “Төрийн аудитын” гэсний өмнө “Улсын Их Хурлын Тамгын газар болон” гэж, 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийн “сонсголын тухай” гэсний дараа “болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “хэсэг, түр хорооны” гэснийг “хэсгийн” гэж, 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн “Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах” гэснийг “энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтын “хэлэлцүүлгийн шатны” гэснийг “хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатны” гэж, 23 дугаар зүйлийн гарчгийн “Төсвийн төслийн” гэснийг “Хоёр дахь” гэж, мөн зүйлийн 23.1, 23.4 дэх хэсгийн “Төсвийн төслийн” гэснийг “Хоёр дахь” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “явуулна” гэснийг “явуулж болно” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалтын “дүгнэлт, шаардлагатай бол тогтоолын төсөл боловсруулж” гэснийг “дүгнэлтээ” гэж, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “Цахим нотлох баримтыг бичмэл нотлох баримтад тооцно.” гэснийг “Бичмэл нотлох баримт нь цахим хэлбэртэй байж болно.” гэж, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “томилно. Хянан шалгагч томилох тухай түр хорооны тогтоолд хянан шалгагчийн ажлын даалгавар, шаардлагатай бол ажиллах хугацааг тогтооно.” гэснийг “томилж, ажлын даалгаврыг батална.” гэж, мөн зүйлийн 44.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 44.3.2-т заасны дагуу нотлох баримтыг гаргаж өгөөгүй бол хянан шалгагч энэ хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу нотлох баримтыг цуглуулах тухай тогтоол гаргуулах саналаа түр хороонд гаргана.” гэснийг “Хяналт шалгалтын явцад нотлох баримт гаргуулах шаардлагатай гэж үзвэл хянан шалгагч энэ хуулийн 37.1-д заасны дагуу тогтоол гаргуулах саналаа түр хороонд оруулна.” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “Хянан шалгах түр хорооны сонсголд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хуралдааны явцад дуу, эсхүл дүрсний бичлэг хийх, зураг авахыг хориглоно.” гэснийг “Энэ хуулийн 46.2-т заасан оролцогчид сонсголын явцад дуу, эсхүл дүрсний бичлэг хийх, зураг авахыг хориглоно.” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Улсын Их Хурал хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан /цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх/-тай байна.

5.2.Мэдээллийн нэгдсэн сан нь Улсын Их Хурлаас явуулсан хяналт шалгалтын холбогдох баримт бичиг, мэдээлэл болон хяналт шалгалтын бусад байгууллагаас гаргуулж авсан мэдээлэл, хууль тогтоомжид заасан бусад тогтмол мэдээллээс бүрдэх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн нэгдсэн сан олон нийтэд нээлттэй байна.”

“30.1.Байнгын хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсгол даргалагчийг сонгох бөгөөд сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална. Сонсгол даргалагч Нийтийн сонсголын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ.”

4.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.3, 25.4 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.3, 28.2.4 дэх заалтын “, түр” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн “, түр хорооны гишүүнийг томилох санал” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14

Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

1.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

2.1.Чуулганы нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөнтэй холбоотой саналын томьёолол:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт буюу 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг нэмэх:

2/12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг:

“12.4.Нэр дэвшигчийн сонсголд оролцогч гэж энэ хуулийн 10.2-т заасан оролцогчдыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 23¹ дүгээр зүйл нэмэх:

3/23¹ дүгээр зүйл.Сонсголын зардал

“23¹ дүгээр зүйл.Сонсголын зардал

23¹.1.Сонсгол зохион байгуулахтай холбогдон гарах аливаа зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, төслийн дугаар өөрчлөх:

“3 дугаар зүйл.Нийтийн сонсголын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйл.Үндсэн болон тусгай зарчим:

“3 дугаар зүйл.Үндсэн болон тусгай зарчим

3.1.Нийтийн сонсголыг зохион байгуулахад ардчилсан ёс, хууль дээдлэх, баримт, мэдээлэлд үндэслэсэн байх, талуудын оролцоог тэгш хангах, иргэний мэдэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах, үр нөлөөтэй байх үндсэн зарчмыг удирдлага болгоно.

3.2.Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулахад дараах тусгай зарчмыг баримтална:

3.2.1.нэр дэвшигчдэд тэнцвэртэй хандах;

3.2.2.нэр дэвшигч, оролцогчдод хүндэтгэлтэй хандах;

3.2.3.ил тод, нээлттэй байх.

3.3.Энэ хуулийн 3.2-т заасан тусгай зарчмыг доор дурдсан агуулгаар ойлгоно:

3.3.1.“нэр дэвшигчдэд тэнцвэртэй хандах” гэж нэр дэвшигчийн албан тушаалын болон бусад байдлаас үл хамааран асуултад хариулах, санал хэлэх боломжийг бүх нэр дэвшигчид тэгш олгох бөгөөд аль нэг нэр дэвшигчид давуу байдал олгохгүй байхыг;

3.3.2.“нэр дэвшигч, оролцогчдод хүндэтгэлтэй хандах” гэж албан тушаалын болон бусад байдлаас үл хамааран нэр дэвшигч, оролцогчоос асуулт асуух, үг хэлэхдээ хүндэтгэлтэй хандахыг;

3.3.3.“ил тод, нээлттэй байх” гэж нэр дэвшигчийн сонсголд оролцох хүсэлт гаргасан бол хуулийн үндэслэлгүйгээр татгалзахгүй байх, сонсголыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд, бүрэн дамжуулах, сонсголын тэмдэглэл ил тод байх, оролцогчид тэмдэглэлтэй танилцаж өөрийн саналыг хянах боломжтой байхыг.”

2/10 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсгол:

“10 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсгол

10.1.Энэ хуулийн 6.2.4, 6.2.7, 6.2.8-д заасан сонсголыг нэр дэвшигчийн сонсгол гэх бөгөөд тэдгээрийг зохион байгуулж, явуулахдаа Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай болон холбогдох бусад хуулийг баримтална.

10.2.Нэр дэвшигчийн сонсголд нэр дэвшигч, түүнийг Улсын Их Хуралд танилцуулах эрх бүхий этгээд, эсхүл түүний төлөөлөгч, нэр дэвшигчээс асуулт асуух, нэр дэвшигч нь тухайн албан тушаалд тавигдах шаардлага хангасан эсэх талаар санал хэлэх, мэдээлэл өгөхөөр хүсэлт гаргасан болон хуульд заасны дагуу мэдээлэл өгөх иргэн, хуулийн этгээд, ажиглагч оролцоно.

10.3.Нэр дэвшигчийн сонсголын асуулт, санал болон холбогдох мэдээлэл нь нэр дэвшигчийн мэдлэг, ур чадвар, туршлага, мэргэшил, ёс зүй, хараат бус, бие даан ажиллах чадвар, томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлийн талаар байна.

10.4.Нэр дэвшигчийн сонсголотой холбогдуулан мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, иргэн, хэвлэл, мэдээллийн төлөөлөл оролцох хүсэлт гаргасан бол тэдгээрийг сонсголд заавал оролцуулна.”

3/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:

“12.3.Сонсголыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих талаар хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийг ажиглагч гэнэ. Ажиглагч нь сонсголын үед нэр дэвшигчээс болон бусад оролцогчдоос асуулт асуух, үг хэлэх эрх эдлэхгүй.”

4/15 дугаар зүйл.Сонсголд оролцогчийн эрх, үүрэг:

“15 дугаар зүйл.Сонсголд оролцогчийн эрх, үүрэг

15.1.Сонсголд оролцогч дараах нийтлэг эрх эдэлнэ:

15.1.1.энэ хууль болон холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу асуултад хариулах, тайлбар, санал хэлэх;

15.1.2.сонсголын тэмдэглэл, гарсан шийдвэртэй танилцах, өөрийн хэлсэн санал, тайлбарыг хянах;

15.1.3.сонсгол зохион байгуулагч болон даргалагчаас тэнцвэртэй, хүндэтгэлтэй хандахыг шаардах;

15.1.4.холбогдох бусад хууль тогтоомжид заасан эрх эдлэх.

15.2.Сонсголд оролцогч дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

15.2.1.сонсгол зохион байгуулагчийн дуудсанаар сонсголд хүрэлцэн ирэх;

15.2.2.сонсголын дэг сахих;

15.2.3.сонсгол зохион байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

15.2.4.сонсголд үнэн зөв мэдүүлэх, бодитой дүгнэлт өгөх;

15.2.5.холбогдох бусад хууль тогтоомжид заасан үүрэг хүлээх.

15.3.Сонсголд оролцогч нь сонсголын явцад бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох, яриаг нь таслах, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.

15.4.Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор сонсголыг дохионы хэлмэрчтэй явуулна.

15.5.Сонсгол зохион байгуулагч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонсголд оролцох, ажиглах боломжийг хангана.”

5/17 дугаар зүйл.Сонсгол даргалагч, түүний эрх, үүрэг:

“17 дугаар зүйл.Сонсгол даргалагч, түүний эрх, үүрэг

17.1.Сонсгол даргалагч сонсголыг хуульд заасны дагуу удирдан зохион байгуулах, сонсголын асуудлыг тал бүрээс нь үнэн бодитойгоор тогтоох, сонсголд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх, оролцогчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, сонсголын дэг сахиулах үүрэгтэй.

17.2.Сонсгол даргалагчийг сонгох, томилох асуудлыг энэ хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

17.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлаас зохион байгуулах сонсголын даргалагчийг Байнгын, дэд хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно. Сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална.

17.4.Сонсгол даргалагч дараах нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

17.4.1.сонсголын бэлтгэлийг хангах;

17.4.2.сонсголыг товлосон цагт эхлүүлж, дэгийн дагуу явуулах;

17.4.3.сонсголд оролцож байгаа этгээдэд асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх;

17.4.4.сонсголын тайланг хянаж, эрх бүхий этгээдэд танилцуулах;

17.4.5.хүндэтгэн үзэх шалтгаантай оролцогчид чөлөө өгөх;

17.4.6.сонсголын дэг сахиулах, оролцогчдоос дэг сахихыг шаардах;

17.4.7.сонсголын дэг зөрчигчид холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах;

17.4.8.сонсголын асуулт, хариулт, тайлбар, санал, мэдээлэл нь сонсголын сэдэвт хамааралгүй, ялгаварлан гадуурхсан, доромжилсон үг хэллэг хэрэглэсэн бол таслан зогсоох;

17.4.9.сонсголын дэг зөрчсөн, эсхүл энэ хуулийн 15.3-т заасан үйлдэл гаргасан оролцогчид сануулах, зайлшгүй шаардлагатай бол үг хэлэх эрхийг нь хасах;

17.4.10.сонсголын тогтсон сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сануулга өгөх;

17.4.11.сонсголын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг танхимаас гаргах.”

6/18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэг:

“18.8.Сонсгол явуулах талаарх хүсэлт гаргах, тус хүсэлтийг шийдвэрлэх, сонсголын товыг зарлан мэдээлэх, сонсгол зохион байгуулах үйл явц, бүртгэл, сонсголын ирц, үе шат, сонсгол даргалагчийг сонгох, түүний эрх, үүрэг, сонсголын дэг болон сонсголын тэмдэглэл, тайлан гаргахтай холбогдсон харилцааг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон энэ хуулийн 18.7-д заасан журмаар нарийвчлан зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	17
Татгалзсан:	22
Бүгд:	39

43.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	17
Татгалзсан:	22
Бүгд:	39

43.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	17
Бүгд:	39

56.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Дээрх 3 дахь саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “20 дугаар зүйлийн” гэсний өмнө “мөн зүйлийн 18.7 дахь хэсгийн “батална.” гэснийг “баталж болно.” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 18.9 дэх хэсэг, төслийн 3 дугаар зүйлийн “10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “нийт гишүүний дөрөвний нэгээс” гэснийг “есөөс” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төсөлд доор дурдсан агуулга бүхий 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Нийтийн сонсголын тухай хуулийн 11¹ дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Чуулганы нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулах
чиглэл өгсөнтэй холбоотой саналын томьёолол:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 15.33 дугаар зүйлийн гарчгийн “15.33 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтад саад учруулах” гэснийг “15.33 дугаар зүйл.Парламентыг үл хүндэтгэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмэх:

“6.Энэ зүйлийн 1-5 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан болон Улсын Их Хурлаас зохион байгуулах сонсголд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаан, сонсголд оролцсон этгээд дэг зөрчсөн, санаатайгаар худал мэдээлэл өгсөн, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар албан тушаалтанд оногдуулсан үүргийг хугацаанд нь биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол хүнийг нэг зуугаас гурван зуун нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянгаас дөрвөн мянган нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

**Чуулганы нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулах
чиглэл өгсөнтэй холбоотой саналын томьёолол:**

Г.Занданшатар: Төслийн 3 дугаар зүйлийн “9 дүгээр зүйлийн” гэсний өмнө “8 дугаар зүйлийн 8.4.3 дахь хэсгийн “байгууллагад” гэснийг “байгууллага, Улсын Их Хуралд” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 12 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

За дараагийн асуудалд орно. Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Улсын Их Хурлын эрхэм гишүүн Сүхбаатар танилцуулна. Ажлын хэсгийн дарга Сүхбаатар гишүүн танилцуулъя.

Ж.Сүхбаатар: Улсын Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүн 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ. Тус байнгын хороо Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, С.Бямбацогт, Д.Тогтохсүрэн, Г.Занданшатар нар асуулт асууж хариулт авч, санал хэлсэн болно.

Байнгын хороо хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй холбогдох 8 зарчмын зөрүүтэй саналын томъёолол, хамт өргөн мэдүүлсэн нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох 6 зарчмын зөрүүтэй санал, мөн хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлтэй холбогдох 2 зарчмын зөрүүтэй саналаар, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй холбогдох 3 зарчмын зөрүүтэй саналаар.

Нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед санал хурааж дэмжсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудтай холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг зүйл, хэсэг, заалт, ишлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн төсөлтэй холбогдох найруулгын 4 багц санал, хамт өргөн мэдүүлсэн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох 1 саналаар санал хураалт явуулж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг хасах зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй

холбогдуулан хамт өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулах нь зүйтэй гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзлээ.

Улсын Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал хураалгахаар санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр нь дахин санал хураалгах шаардлагагүй гэж үзсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд, байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүдийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Улсын Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга, Монголын хянан шалгах үнэлгээний газрын дарга Сономжамцийн Янжинхорлоо. Монгол Улсын их сургуулийн хууль зүйн сургуулийн багш, үндсэн хууль судлаач, доктор, профессор Одонхүүгийн Мөнхсайхан. Байнгын хороонд танилцуулахтай холбогдуулан асуулт асуух Улсын Улсын Их Хурлын гишүүд байна уу? Шатарбалын Раднасэд гишүүнээр, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууя.

Ц.Даваасүрэн: За нэлээн чухал хууль, яагаад тэгж байна вэ гэвэл сүүлийн 20, 30 жилийн хугацаанд нөгөө үндсэн хуулиар олгосон эрхээсээ Их Хурал нэлээн татгалзаад явчихсан байхгүй юу. Их Хурлаа мөлжсөөр байгаад сулхан болгочихсон. Гэхдээ Их Хурал нь өөрөө төрийн эрх барих дээд байгууллага гэж байгаа боловч яг үнэн хэрэг дээрээ бол тэр эрх мэдлээсээ нэлээн алдчихсан, бас ийм л ер нь бол нэг тийм хүйтэнд нөмгөн хүн шиг л болчихсон л ингээд л байж байгаа. Тэгээд энэ хууль бас нэг Их Хуралд төрийн эрх барих байгууллагад бас үйл ажиллагааг нь дээрдүүлэхэд 1 алхам болох болов уу гэж би ингэж бодоод байгаа юм. Гэтэл тэр хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, ялангуяа хууль тогтоох байгууллагуудын хуулийн хэрэгжилт хяналт тавих чиглэлд бид нар анхаарах ёстой.

Би өглөө ч хэлсэн. Улс төрийн хэргүүд, улс төрийн албан тушаалтай том хэргүүдийг бол чадахгүй байгаа байхгүй юу. За тэр Зоригийн хүн амины хэрэг, тэр Төмөр-Очирын хэрэг, сүүлд Батхүүгийнх юу болсон нь мэдэхгүй, ямар ч эзэн байхгүй, ийм юмыг бол шууд энэ дээр дуудаж ирээд, тэр ёстой Америк шиг библийг нь уншуулж байгаад гэдэг шиг нэг ийм тангараг өргүүлж байгаад ингээд сонсдог байх хэрэгтэй. Тэгж байж ийм хэргүүд цэгцэрнэ. Ийм хэргүүдийг цэгцлэхгүй яваад байх юм бол улс төрийн ийм захиалгат гэмт хэргүүд бол олширно шүү дээ. Дутуу

хаяад байх тусам олширно. Тийм учраас хууль дээр байсан тэр нэг мөрдөн шалгах гэдэг заалт ер нь хэр суларчихсан бэ? Би сүүлд нэлээн суларчихсан л харагдана лээ.

Би Сүхбаатартаа бас талаар ярьсан. Тэр талаар би нэг тодруулъя гэж бодож байгаа юм. Би зүгээр нэг жишээ хэлье. Их Хурлаас Засгийн газрын гишүүндээ хариуцлага тооцож байгааг огцруулж байгааг бол буруу байна. Сайд нар айгаад ажиллаж чадахгүй байна гэсээр байгаад л авсан. За 2 ч удаа бид нар ингээд сайд нар, Ерөнхий сайд нь томилж оруулж ирлээ. Тэгээд энэ 2 Засгийн газар гялалзсан уу? өмнөх засгийн газруудаас өөр байж чадсан уу? Бид нар ингэж л ханддаг байх шүү. Тэрнээс биш тэгээд л үндсэн хууль бол дуртай цагтаа гар дүрээд л, дуртай цагтаа өөрчлөөд байдаг байж болохгүй шүү дээ. Засгийн газар үнэхээр мундаг болсон уу? хуулийг хийсэн хүмүүсээс би асууя.

Эрх мэдэл өгсөн Засгийн газарт, харин эцсийн дүндээ төрийн эрх барих дээд байгууллага нь ажилдаа эзэн болж чадахгүй байгаа байхгүй юу. Би түрүүн шаардсан шүү дээ. Энд орж ирсэн хүн яахаараа дутуу хариулж байгаа юм. Би яг хуулийн дагуу юмыг нь асуусан шүү дээ. Тэр 800 хулгайч чинь бол гаднын нөхдүүд энд орж ирээд л кибер гэмт хэрэг хийгээд л мөнгө угаасан байсан шүү дээ. Би тэрийг л асуусан шүү дээ. Тэрийг хүртэл шийдэж чадахгүй байгаа байхгүй юу. Тэгээд төрийн эрх барих дээд байгууллага дээр ирчхээд асуулт, нэг тодорхой зүйлээр асуучих юм бол бичгээр хариулъя гээд л, ингээд л гараад явдаг болсон. Хуучин бол тэгдэггүй байсан байхгүй юу. Тэгдэггүй байсан. Ер нь Улсын Их Хурлын нэр хүнд гэдэг юм ер нь шалдаа бууцан шүү. Өөрсдөө ийм байгаад байхаар чинь биднийг хэн тоох юм бэ. Өөрсдөө ажилдаа эзэн болж чадахгүй болохоор чинь хэн ч тоохгүй шүү дээ. Тийм учраас төр сул байгаа юм.

Төр ажилдаа эзэн болж чадах ёстой. Тэр талаасаа би хяналт шалгалтын хуулийг, Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд хяналтаа гүйцэд тавьдаг болоо л гэж, гүйцэд тавьдаг бол. Тэгж чадах юм бол чинь өөр болно шүү дээ. Бас нэг айх юмтай байх ёстой шүү дээ. Нөгөө айлгадаг нь ингээд марзганаад суугаад байхаар чинь.../минут дуусав/

Г.Занданшатар: Ажлын хэсгийн дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Мөрдөн шалгаах тэр асуудал дээр бол яахав юу яасан, нөгөө, мөрдөн шалгах гэдэг үгэн дээр бол бас манай ажлын хэсгийн хүрээнд ярьсан, гишүүд бас болгоомжилсон юм бол нөгөө эрүүгийн хэрэг мөрдөн шалгадаг ажиллагааны асуудалтай давхардсан ийм асуудлууд ойлгогдчих гээд байгаа учраас энэ “мөрдөн” гэдэг үг чинь бас жоохон тийм байна гээд ингээд ярилцаад энийг бол ажлын хэсгийн ахлагчийн хувьд бас ийм улсуудтайгаа ярьж зөвшилцөх үүднээс бол тусгай шалгалт гэдэг агуулга руу нь оруулаад ер нь бол таны хэлдэг үнэн л дээ. Ер нь гаднын Англи дээрээ ч, Орос дээрээ ч яах аргагүй л “парламентын мөрдөн шалгалт” гэж үг байгаа юм “parliamentское расследовани” нөгөөдөх нь болохоор “parliament inquiry investigation” гээд. Тэгээд энэ асуудлын хүрээнд агуулга нь бол өөрчлөгдөөгүй. Түр хорооны тэр дотоод механизмын хувьд бол гэрч, шинжээч дуудах асуудлууд дээр цөөнх, олонхын асуудлын хүрээний асуудал дээр жоохон зохицуулалт нь бол өөрчлөгдсөн байгаа. Хэтэрхий цөөнх нь бас ингээд бужигнуулаад байх вий гээд ийм юм л яриад байсан юм.

Тэгээд ер нь таны хэлдэг асуудлаар бол яах аргагүй парламентын мөрдөн шалгалтын арга хэрэгсэл бусад улс оронд байдаг арга хэрэгсэл манай парламентад байдаггүй учраас сонгодог яг тэр парламентынх нь шинжийг хяналт шалгалтын тэр хүчирхэг арга хэрэгсэл механизмгүй явж ирсэн. 30 жилийн ойн босгон дээрээ ийм хяналт шалгалтын механизмтай болж байна. Бид чинь яг хүний эрх хамгаалъя, авлигатай тэмцье гэж байна.

Яг өнөөдрийн парламентын хүний эрхийг хамгаалдаг илд бамбай бол Улсын Их Хурлын парламентын хяналт шалгалт байж байгаа. Тэр дундаа мөрдөн шалгалт. За яг та бол их чухал юм хэлсэн. Зарим улсууд маань бас жаахан ойлгохгүй байгаад байгаа юм, би тэрийг бол та яг хэлж байна. Зарим хэргүүд бол илэрдэггүй, тэр илэрдэггүй хэргүүдийг бусад улс орон бол яг парламентын мөрдөн шалгалтын хүрээнд илрүүлдэг олон жил тэгээд л шалгагдаж байгаа, шүүх дээр байгаа, мөрдөн байцаалт дээр байгаа гээд л ингээд л явуулаад байдаг юмнууд байдаг. Сая ч гэсэн би Зоригийн хэрэг дээр оролцдог чинь түр хороо байгуулж явсан шүү дээ. Тэгээд манай ажлын хэсэг ч гэсэн бас юмаа хумья гэдэг юм бас орж ирсэн саналыг бас дэмжээгүй. Энийгээ хадгалж үлдье бас ийм боломжоо хадгалж үлдье.

Ер нь бол энэ хууль гарсны дараа бол Монгол Улсын Их Хурал 30 жилийн дараа бол парламент хууль тогтоодгоос гадна хуулийн биелэлтийн араас явдаг, дандаа цөөн хууль гаргаад л, тэгээд маш олон сонсгол хийх гэж байна гээд манай зарим хүмүүс тээршээгээд байгаа юм. Үгүй л дээ, сонсгол гэдэг бол хяналтын, бид нар ерөнхий хяналтын гээд, таны түрүүнд сая хэлж байна. Хууль тогтоомжийн араас хэрхэн биелэгдэж байгааг хянадаг ерөнхий хяналтын сонсголотой болж байгаа. За мөн Тамгын газар маань бидний даалгавар, үүрэг даалгавраар байнгын хорооныхоо нь чиглэлээр хууль тогтоомжид үр нөлөөнд үнэлгээ хийдэг болох гэж байгаа юм. Апаратыг, хүчирхэг болгох шаардлагатай болж байгаа. Энэ хууль гарангуут Тамгын газрын бүтэц орон тоонд, бас чиг үүрэгт бас нэлээн том өөрчлөлт орно. Ингээд нэг тийм хянан шалгадаг эрхтэй гэж байгаа боловч төсөв мөнгө бусад талаасаа бол бид чинь яг тэр талын боломж нөхцөл бол муутай байсан.

Энэ хуулийн гол зорилго бол явж, явж иргэдийн мэдэх эрхийг хангах, иргэдийн оролцоог хангахдаа гол нь энэ хуулиа биелүүлж, хүний эрхийг хамгаалж тодорхой хэмжээнд албан тушаалтнуудын асуудал дээр, ялангуяа Засгийн газар дээр холбоотой асуудал дээр Улсын Их Хурал бас авилгатай тэмцье гэж байгаа бодлогынхоо хүрээнд бол яг явцад нийцэж байгаа. Ийм байгаа юм. Тэгээд мэдээж хуулийг гаргасны дараа бол бид илүү сайжруулаад явах бололцоо бий.

Ер нь бол Оросын Холбооны Улс чинь бүр 2005 онд ийм парламентын мөрдөн шалгах юмаа хуульчилчихсан улс жишээлбэл. Тэгтэл бид дөнгөж одоо ярьж байх жишээтэй. Тэгээд яах вэ үгнээс нь бол нэг жоохон цэрвээд байсан учраас нэг тийм тусгай гэдэг агуулгаар парламентын тусгай гээд, түрүүний таны хэлдэг асуудал дээр ер нь парламентыг үл хүндэтгэх гэдэг тэр юм бол бас энд давхар бас явж байгаа. Ер нь парламентыг үл хүндэтгэсэн юманд нь дуудаад ирдэггүй, юм хумаа гаргаж өгдөггүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх эзэн .../минут дусав/

Г.Занданшатар: Цэрэнпэлийн Даваасүрэн гишүүн тодруулъя.

Ц.Даваасүрэн: Тийм, бас ч яах вэ энэ удаагийн парламентын хүрээнд хийгдэж байгаа маш том ахиц. Өмнө нь ерөөсөө хийж чаддаггүй байсан. Харин би ахиц гэдгийг бол зөвшөөрч байна. Тэгэхдээ мөлийчихөөгүй би бас зүгээр нэр өөрчилсөн юм байна гэж ингэж ойлголоо шүү. Зоригийн хэргийг яах юм? Хууль зүйн

сайд нь худлаа гээд, прокурор, тагнуул 2 нь үнэн гээд. Үгүй, энийг хэн хагалах юм? Их Хурал шүү дээ. Нөгөө талаараа улс төрчдийн хэрэг байна, хүчний байгууллагынхны хэрэг байна. Би бүр өөр дээр нэг жишээ хэлье. Сэлэнгийн Мандал суманд нэг эрчим хүчний тендер болсон. Тэр мөнгийг нь гүйцэтгэлгүй аваад явчихсан. Би тэгээд ямар улсууд оролцсон гээд тэгэхээр хүчнийхэн гэдэг, тэгээд би Улсын Ерөнхий Прокурорт өгсөн, Хууль зүйн сайдад өгсөн. Энийг шалга. Хэн нь ч шалгахгүй байгаа байхгүй юу. Усанд хаясан чулуу шиг алга болсон. Тэгээд хүчний байгууллага нь өөрсдөө ийм юманд оролцоод байвал яаж авилгатай тэмцэх юм бэ, яаж авилгатай. Тэр Сэлэнгийн Мандалыг бол дуусаагүй гэж бодож байна.

Г.Занданшатар: Сүхбаатар гишүүн хариулах уу? Жамъянхорлоогийн Сүхбаатар.

Ж.Сүхбаатар: Ер нь бол хууль санаачлагч, манай Бямбацогт гишүүн эд нар сууж байна. Ер нь яг таны саяын хэлдэг дээр асуудал агуулгаар бол хандсан. Манай гишүүд ч гэсэн бас ойлгож хүлээж аваасай гэж бодон Улсын Их Хурал юу юугүй та бол 2 хандлага явагдаад байгаа юм. Нэг хэсэг нь бол ер нь Улсын Их Хурал ерөөсөө замбараагүй бүх юманд ордог гээд л нэг шүүмжлэл дотроосоо ч бас яриад байна шүү дээ. Гэтэл та бол нөгөө талаас нь бол маш их сул байгаа шүү дээ гэж байна. Би бол тэр сул байгаа талд нь бол санал бодлоо хуваалцаж байгаа хүмүүсийн нэг, гишүүдийн нэг.

Тийм учраас хууль нь яах вэ, зарим нэг юманд мөлийчихлөө гээд нэг юм яригдсан. Гэхдээ яг агуулгын хувьд бол мөлийчихлөө гэдэг нь илүү юун дээр яригдсан бэ гэхээр тэр олонх, цөөнхийн харилцааны асуудал дээр л яригдсан юм. Тэрнээс биш Улсын Улсын Их Хурлын яг өөрийгөө шалгах тэр тал дээр бол бид нарын юм бол мөлийсэн юм бол яг байхгүй харин зарим хүн чинь бараг чинь жоохон хумихаар юм биш үү гэдэг хүртэл ажлын хэсэг дээр байнгын хороон дээр яриад байсан байх. Тэгэхээр та бүхэн маань дэмжээд энэ хэлбэрээр нь өгөх юм бол ер нь бол нэг тэнцвэр зохистой.../минут дуусав/

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: За баярлалаа. Ер нь хяналт шалгалтын хууль бол маш чухал хууль л даа. Бүх л парламенттай оронд, ялангуяа хөгжилтэй орнуудад бол дандаа байдаг, ийм хууль. Манайд 30 жил парламентын засаглалдаа шилжсэн мөртөө энэ хууль хэрэгжээгүй. Нэг ёсондоо хүнээр бол өрөөсөн гараараа ажиллаж байсан гэсэн үг. Тийм. Хууль гаргаад байдаг хууль тогтоогч болоод л байдаг. Яг тэр хуулийнхаа биелэлт, хэрэгжилт дээр хяналт тавихдаа хуулийн хангагдаж ажиллахгүй байсан. Ер нь бол Улсын Их Хурал хууль тогтоох байгууллага гэж зөвхөн хэлэх биш хууль тогтоох, хяналт хэрэгжүүлэх байгууллага юм шүү дээ. Ялангуяа энэ хууль гарснаараа бол тэр түрүүний Даваасүрэн гишүүний хэлдэг хүчний байгууллагуудын зүй бусын буруу шийдвэр гаргадаг, дураараа авирладаг, нөгөө Монголчуудын хэлдгээр төгсгөдөг хүмүүсийг энэ байдал бол дээр хяналт тавина. Нэг хэсэг хэтэрсэн шүү дээ. Ялангуяа ноотой улс төрчдийг бол хөдөлгөхгүй болсон, дураараа авирласан, сэлэм сугалж байгаа юм шиг л айлгадаг болсон. Энэ байдал арилна гэж бодож байна.

Ер нь ард түмний төлөөлөл учраас Улсын Их Хурлын гишүүн ард түмний нэрийн өмнөөс хууль тогтоох, зөвхөн хууль тогтоогоод байх биш хяналтыг бол дээд шатанд нь, ялангуяа хууль хүчний байгууллага дээр бол үнэхээр сайн тавих ёстой. Түүнээс гадна түрүүний хэлдгээр энэ хууль гарснаараа бүх юманд гүйцэтгэлийн

юманд хутгалдаж орохгүй. Салбарын яамдын бүх жижиг ажилд, дотоод ажилд оролцоод байхгүй томоохон асуудал жишээ нь Эрдэнэт шиг асуудал дээр, тэнд мафи явагдсан шүү дээ. Яг тийм асуудал дээр яг чиглэж хяналтаа тавьж хэрэгжүүлнэ гэж ойлгож байгаа юм. Хамгийн санаа зовж байгаа зүйл бол манайх Монголчилно гэж ярьдаг. Тэгээд нуухыг нь авах гээд нүдийг нь сохолно гэгчээр гаднын оронд хэрэгжиж байгаа тэр хуулиудын хүч чадлыг муутгаад. Тэгээд нөгөө үлбэгэр хууль болгочих вий, энэ хуулиар бол нотлох баримт бүрдүүлнэ, мөрдөн шалгах, гэрч дуудаж ирүүлэх гэж байгаа мөрдөн шалгах гэдэг үгийг нь тусгай ажиллагаа гэсэн үү? юу гэсэн? тийм үгээр сольсон гэв үү? Ер нь их муутгаж л болохгүй шүү, ер нь тэгэхдээ бол бид шинэ юм зохиох биш парламенттай оронд хэрэгжсэн аль улсын парламентаас илүү түлхүү, хуулийн жишээ авч хэрэгжүүлсэн бэ? гэдгийг бас асуумаар байна.

Ер нь хууль хэрэгжиж, гарснаар Их Хурал болж хүнээр бол нэг талдаа бол 2 гараараа ажиллаж, нэг талдаа хуулиа тогтоон, нөгөө талаас талдаа бол хуулийнхаа хэрэгжилт дээр хяналт тавьж ард түмний төлөөлөл гэдэг жинхэнэ утгаараа ажиллах ийм боломж бүрдэнэ гэж ойлгож байна. Мөн үү? За баярлалаа.

Г.Занданшатар: Сүхбаатар гишүүн асуултад хариулъя. Ажлын хэсэг.

Ж.Сүхбаатар: Энэ хуулийн та хэлж байна. Ер нь бол бид дэлхийн жишгийг л барих ёстой. Тэгээд яг дээр бол Монголын тодорхой хэмжээний онцлог байх ч гэсэн яах аргагүй парламентын хяналт, шалгалт гэдэг бол дэлхий дахинд хэвшээд тогтчихсон, манайдаа л шинэвтэр маягийн юм болчихоод байгаа.

Хууль санаачлагч бол судалгаа нэлээн тооцоо юмнуудаа хийсэн Улсын Улсын Их Хурлын дарга бол ер нь бол 2 жилийн өмнөөс бид нар бас ажиллаж байх үед Германы парламентын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт батлагдсаны дараа л Германы парламентын жишиг хуулиудыг орчуулуулах асуудлыг ярьж хөөцөлдсөн. За сая сүүлд хууль санаачлагч Бямбацогт нарын гишүүдийн үед бол ингээд юмаа суурилад Мөнхсайхан доктор эд нар ажиллаж байна бусад дэлхийн олон орнуудын судалгаа хийсэн. Гэхдээ ер нь гол барьсан загвар маань бол, ер нь бол бид нарын хуулийн гол онцлог бол Герман маягийн юм шүү дээ. Парламентынхан бүгд найрамдах улсынхаа шинжийг бол баримталж ингэж хийсэн. За мөн онцлог юм нь бол хууль санаачлагч, бас өөрөө хөгжлийн бодлого төлөвлөлттэй холбоотой Засгийн газрын тайлан мэдээ илтгэлүүдийг яг бодитой болгох чиглэлд нь анхаарсан.

Ер нь манай Улсын Их Хурлын хяналт шалгалтын хэлбэр бол ажлын хэсгийн хэлбэр байсан. За сүүлийн үед бол бид хэдийгээр энэ хууль гараагүй ч гэсэн нийтийн сонсголын хууль гаргах, ер нь сонсгол болон сонгон шалгаруулалтын асуудлуудыг ингээд нэвтрүүлэх эхний алхмууд бас хийгдсэн хуулиас өмнө. Тэгэхээр энэ хууль гарснаар бол ингээд бодитой, яг ингээд болоод бүүр хугацаатай, Байнгын хороо гэхэд Засгийн газарт яг тогтоолоор чиглэл өгнө, хугацаатай Улсын Их Хурал шийдвэр гаргана, тэгээд тэрийг нь яг хугацаатай тайланг нь тодорхой хугацаатай яг сонсож байна гэдэг ч юм уу. Яг энэ болгон бол ингээд тодорхой цаг хугацаатайгаар ингэж хийгдээд, бас араас нь хариуцлагын механизмуудыг хийж байгаа юм.

За ингээд юмаа биелүүлэхгүй байх юм бол хариуцлага хүлээлгэх асуудлаар шийдвэр гаргана тэр гээд болгоныг бол ингээд нэлээн тодорхой болгож цэгцэд оруулсан тийм хяналт шалгалтын жишээлбэл асуулт асуулга гэхэд зааг ялгааг нь бүдэг байсныг нь бид нар тодруулж өгсөн ч гэдэг юм уу.

За мөн Улсын Их Хурлаас томилогддог байгууллагуудын удирдлагуудын тайлан мэдээллийг сонсохоос авхуулаад гэдэг юм уу. Ингээд цогцоор нь энийг авч үзэж, яг хууль гарсны дараа бол бид нэг их олон улсын жишигт хүрсэн гэж хэлэхгүй ч ядаж ойртсон гэж хэлж болно. За би бол хүрсэн байх гэж найдаж байна. Тэгэхээр бол манай байнгын хороо, та бол байнгын хорооны дарга, байнгын хорооны хувьд бол ажиллаад ингээд явахад бол их эвтэйхэн болох болов уу гэж бодож байна. Бид бол хэлж байна шүү дээ. 30 жилийн дараа нэг ийм тусдаа өөрийн гэсэн хуультай, тэгээд Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт оруулсан бодлогын том цөм хэсэг нь энэ л дээ. Парламентын ард түмний засаглах бүрэн эрхийг хангая гэж байгаа нь яаж байгаа юм бэ гэхээр ард түмний төлөөлөгчдийн байгууллага, тэдний нэрийн өмнөөс хууль тогтоосон юм бол тэднийхээ араас шийдвэрийг нь, гүйцэтгэлийг нь бодлого, хууль яагаад амьдрал биелэхгүй байгаа юм. Тэрнийх нь араас явдаг илүү цагаа тэр хуулийг хянан, биелэлтэд нь хяналт тавих, тэр чиглэлд нь Улсын Их Хурлын гишүүд хөөцөлддөг байх.

Нийгэмд үүсээд байгаа тодорхой кэйс хэргүүдийг бид шийддэг, тэр дээр нь анализ хийдэг, иргэдийн оролцоог хангаж, сонсдог энэ хэлбэрээр бол Улсын Их Хурал дараачийнхаа хөгжлийн 30 жилийн гарааг бол энэ хууль гарснаар бол ирэх жил бид нар Үндсэн хуулийн 30 жилийн ой болно. Манай парламентын хөгжлийн 30 жилийн ой сая бид тэмдэглээгүй ч гэсэн ингээд болоод явж байна. Тэгэхээр энэ болгон бол бид нарт бас ийм цаг хугацааны гарааны хувьд бол ийм болж байна. Тэгээд хууль дотор тэр хүний эрх, эрх чөлөөг хангах хяналтын сонсгол, төсвийн хяналтын нь сонсгол, ерөнхий хяналтын нь сонсгол, нэр дэвшигчийн сонсгол гээд яг 4 ийм чухал хяналтын сонсголыг оруулаад, хажуугаар нь тэр хянан шалгах түр хороо буюу мөрдөн шалгадаг ийм механизмыг тусгаж өгсөн. Ийм байж байгаа. Тэгээд ингээд гол юм бас дээрээ хоосон байхгүйгээр Улсын Улсын Их Хурлын Тамгын газрыгаа нэлээн бэхжүүлж өгөх тал дээр бол дорвитой яг шийдэл бол энд хий орсон байж байгаа.

Г.Занданшатар: За эрхэм гишүүдээ, энэ эцсийн хэлэлцүүлэг явж байгаа. Тэгээд нэг зүйлийг анхаармаар байна энэ асуулт, хариулт дээр гэнэт сэрсэн юм шиг энэ эцсийн хэлэлцүүлэг дээр л, хэлэлцэх эсэх дээр юм уу, хэдэн жилийн өмнө ярьж байх юмыг асуугаад л тэгсэнгүй, ингэсэнгүй, тийм юм хайчив гээд, ингээд шахаж шаардаад байдаг бол өөрсдөө хариуцлагагүй ажиллаж байгаагийнх шүү. Бямбацогт дарга одоо асуулт асууна.

Бямбацогт даргаар ахлуулсан ажлын хэсгийг чинь жил хагас, 2 жилийн өмнө байгуулаа биз дээ? Тэр бүрэлдэхүүнд Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн, Пүрэвдорж гишүүн юм асуугаад хэлээд байгаа бүх гишүүдийг оруулсан, 2 жил ажиллуулсан. Германы туршлага, өчнөөн улсын хууль орчуулсан. Тэгээд өргөн бариад яваад мөрдөн шалгах тэр нь хасагдаад мөлийлгөх нь мөлийгөөд, зарим нь ингээд санал гаргаад л, ажлын хэсэг нь Нямаагийн Энхболд, Мөнх-Оргил гишүүнтэй, тэгж болохгүй, ингэж болохгүй гээд. Ингээд явж, явж ирсэн хойно гэнэт эцсийн хэлэлцүүлэг дээр ирсэн юм чинь тэр хаачив? наад чинь юу болчхов? хууль байхгүй болчихлоо. Ингэж эцсийн хэлэлцэх хуулийн хэлэлцүүлэгт оролцож таарахгүй шүү гэдгийг зориуд анхааруулж бас хэлмээр байгаа юм.

Тэр мөрдөн шалгах буюу investigative public hearing гэж байдаг. Мөрдөн шалгах нээлттэй сонсголын агуулга байсныг хассан, мөрдөн шалгах гэдэг үгийг нь хассан. Тэгэхдээ тийм сонсгол угаасаа хийж болох, хүчтэй газар бол нотлох сонсгол

гэж хийдэг шүү дээ. Манайх бол зөвшилцөх, өөрсдөө томилдоггүй албан тушаал дээр ч гэсэн Ерөнхийлөгчийн томилдог албан тушаал дээр Ерөнхийлөгчийн засаглалтай улсууд дээр тэр нь зөв байна уу үгүй юу гэдгийг нотолдог, нээлттэй сонсгол хийдэг. Талбайн сонсгол гэж газар дээр нь очиж хийдэг. Мэргэжлийн хяналт буруу ажиллаад байвал очиж тэндээс нь сонсгол хийдэг. Ийм ажлуудыг санаачлаад ажилламаар байгаа байхгүй юу. Тэгээд ингээд гэнэт хууль эцсийн хэлэлцүүлэгт ороод ирэхээр л тэглээ, ингэлээ гээд нийгэмд таалагдах гэж байгаа юм уу, нэг хүнд таалагдах гэж байгаа юм уу? Ийм юм ярьдгаа бол зогсоох хэрэгтэй. За ингээд Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: За Улсын Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд С.Бямбацогт, Ё.Баатарбилэг, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Г.Дамдинням, Л.Мөнхбаатар, Ж.Мөнхбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Н.Наранбаатар, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж, Г.Тэмүүлэн, Б.Энхбаяр нарын гишүүд бид Улсын Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг санаачилсан, нэлээн сууж Улсын Их Хурлын Тамгын газраас туслалцаа авч байж энийг боловсруулсан.

Монгол Улсын Үндсэн хуульд бол Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага Улсын Улсын Их Хурлын гишүүн бол хууль тогтоох, ард түмнийг төлөөлөх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих гэсэн үндсэн 3 бүрэн эрхтэй. 3 бүрэн эрхээсээ үндсэндээ ард түмнийг төлөөлөх, хууль тогтоох гэсэн 2 бүрэн эрхийн бол маш сайн хэрэгжүүлж ирсэн. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд. Харин хуулийн хэрэг хэрэгжилтэд хяналт тавих онцгой бүрэн эрхээ бас хэрэгжүүлэх тал дээр сул ажиллаж ирсэн. Улсын Улсын Их Хурлын тухай хуулийн 1 бүлэг нь л хяналт шалгалтын талаар байдаг байсан. За үүнийг тэгвэл бид нар Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан, Улсын Улсын Их Хурлын 25.1 дүгээр зүйлд заасан Улсын Улсын Их Хурлын хууль, бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах гэсэн онцгой бүрэн эрхтэй. Бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн тулд анхдагч хуулийг анх удаа гарч байгаа хууль санаачилсан юм.

Энэ хуулийг санаачилж баталснаараа бол ажлын хэсэгт баярлаж байгаа бас богино хугацаанд оруулаад ирсэн. Сүхбаатараар ахлуулсан Мөнх-Оргил, Тогтохсүрэн, Нямаагийн Энхболд нарын гишүүд ажлын хэсэг маань сайн ажилласан. Ингээд бас ороод ирж байгаад талархаж байна. За гишүүд санаачилсан гишүүд маань бас санаа зовоод бас зарим зүйл заалт мөлийчихсэн байх вэ? Асууж байх шиг байна. Тэгээд харьцангуй бас л мөлийгөөгүй байх шиг байна гэж би бас харж байгаа, анхаарсан, анзаарсан. Санаачилсан хууль маань мэдээж бас тэмээ оруулсан ч ямаа гарчих бий гэхээс бид нар бас болгоомжилсон. Гайгүй гарч байгаа гэдэгт итгэж байгаа.

Энэ хууль батлагдсанаараа яах гээд байгаа юм гэхээр нөгөө л ард түмэн бас биднийг л хянах гээд байна, шалгах гээд байна гэж битгий ойлгоосой. Тэр ард түмнийг хянаж байгаа, шалгаж байгаа аж, ахуйн нэгж байгууллага, иргэдийг дарамталж байгаа хяналт шалгалтыг цөөлөх гэж байгаа Засгийн газрын бодлого зөв, тэрийг зөв гэж байгаа. Харин Засгийн газар маань хуулийг хэр зэрэг хэрэгжүүлж чадаж байна, төрийн дунд, доод шатанд тийм үү, хууль хэрэгжүүлэх хуулийг сурталчлах, хуулийг сахиулах ажлаа хэрхэн яаж хийж чадаж байна гэдэг дээр. Бид нар үндсэндээ Засгийн газар, Засгийн газрын байгууллагууд, төрийн албан хаагчдыг л энэ Улсын Улсын Их Хурлын бодлого, шийдвэр, төрийн бодлого шийдвэр хэрхэн хэрэгжүүлж байна гэдэг дээр хяналт шалгалтаа хийх гэж байгаа.

Хяналт шалгалт хийхдээ бид нар ярьсан тайлан мэдээлэл, илтгэл сонсох, томилгооны сонсгол, нийтийн сонсгол, хяналтын сонсгол хийх, асуулга, асуулт тавих, за мөн хянан шалгах түр хороо байгуулах, за мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зэрэг бас ийм механизмуудыг ашиглаж хяналт шалгалтыг хийж, энүүгээрээ дамжуулж олон нийтэд, ард түмэнд мэдээлэх, мэдэх эрхийг нь хангах ийм зорилготой. Өөрөөр хэлэх юм бол хууль зөв хэрэгжиж байна уу? буруу хэрэгжиж байна уу? Хууль зөв хэрэгжвэл сайн, буруу хийж байвал яагаад буруу хэрэгжиж байгаа, хууль хэрэгжихгүй бол яагаад хэрэгжихгүй байна гэдэг тал дээр бас үнэлгээ дүгнэлт хийх юм.

Ингэснийхээ үр дүнд, үндсэндээ хяналт шалгалтын үр дүнд хууль хэрэгжихгүй бол хууль хэрэгжүүлэхийг шаардах, шахах, хуулийн хэрэгжилт хангуулах, эрчимжүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, за мөн хяналт шалгалтын үр дүнд шаардлагатай гэж үзэх юм бол холбогдох хууль тогтоомжийг өөрчлөх, мөн шаардлагатай гэж үзэх юм бол хууль хэрэгжүүлэхгүй байгаа, хуулийг буруу хэрэглэж байгаа ард иргэдийг тийм үү? Хүнд суртал гаргаж байгаа албан тушаалтнууд хариуцлага тооцох ийм л байдлаар үндсэндээ хяналт шалгалтын үр дүн гаргуулахаар ийм хуулийг бид нар санаачилсан. Хууль бус заавал биелнэ заавал биелэхдээ бид нар холбогдох албан тушаалтанд хууль хэрэгжүүлэхгүй бол хуулийг буруу хэрэгжүүлбэл, буруу биелүүлбэл хууль сурталчлахгүй бол хуулийн дагуу ажлаа хийхгүй бол хариуцлага тооцох, парламентыг үл хүндэтгэсэн гэж үзээд заавал хариуцлага тооцдог байх механизмыг суулгаж өгсөн.

Ийм учраас энэ хууль бол харьцангуй сайн хууль гарч байгаа. Сайн хэрэгжүүлэхийн тулд Улсын Улсын Их Хурлын гишүүд бид бас нэр төртэй, нэлээн сайн, анхаарч ажиллах ёстой гэж үзэж байгаа. Эцэст нь асуулт алга. Ажлын хэсгийнхэнд бас баярлалаа. Богино хугацаандаа хуулийг оруулж ирсэнд талархаж байна. Хуулиа амьдрал дээр хэрэгжүүлэхийн төлөө бас бүгдээрээ хамтраад ажиллацгаая.

Г.Занданшатар: За хариулах уу? ажлын хэсэг. Ер нь яах вэ энэ дашрамд манай Бямбацогт гишүүнтэй ажлын хэсэг бол их сайн ажилласан шүү. Хариулахад бол хуулийг сайн боловсруулсан. Нэг зүйлийг онцлоод тэмдэглэчихмээр байгаа юм. Улсын Улсын Их Хурлын дарга бол томилгооны эрх мэдлээсээ үндсэндээ татгалзсан гэж болно. Хуучин бол Улсын Улсын Их Хурлын дарга санал болгоод шууд томилдог байсан. Бүгдийг нь нээлттэй сонсголоор оруулдаг болсон. Ер нь нээлттэй сонсгол, шүүлтүүрээр орохоор хуулийг хүн хэрэгжүүлдэг учраас арай дээр хүн томилох эрх зүй бүрдэх юм байна лээ. 1 хүн кармагаасаа гаргаж ирээд, цүнх баригчид гэж нэрлэдэг хүн ч юм уу, 1 хүн томилчихдог биш, нээлттэй сонсголоор орох учраас эрх биш олны босгыг давчихаар, олны хэл ам шуугианд ороогүй, нэр цэвэр, мөр бүтэн хүн байх шаардлагаас авхуулаад л сайн хүн томилогдох үндэс нь нээлттэй сонсох л юм байна лээ. Хэчнээн сайн шүүхийн хууль, хэчнээн сайн тогтолцоо бий болгоод хүн л муу бол ямар ч хууль хэрэгжихгүй.

Тэгэхээр сайн хүн олж, шилж олох гэсэн бодлого бол нээлттэй сонсголоор, томилгооны сонсголоор хэрэгждэг ажлыг Улсын Их Хурал хэвшүүлж байгаа. Энд манай Бямбацогт гишүүнтэй Хууль зүйн байнгын хороо санаачилж ажиллаж байгаа. Тэгээд бол бас ажил хийж байгаа сайн байнгын хороод бол бас ийм тодорхой хуулиуд дээр тодорхой үр дүн гарч байна. Энэ хууль батлагдсанаараа бол хуулийн хэрэгжилт эрс сайжирна гэж бид итгэж байгаа. За ингэж хариулъя, Ингээд Шатарбалын Раднаасэд гишүүн асуулт асууя.

Ш.Раднаасэд: Надад 2 асуулт байна. Энэ хүрээнд, ялангуяа өнгөрсөн 2 жилийн хугацаанд цар тахал гээд ер нь урьд өмнөх Их Хурлуудад байгаагүй их хэмжээний ажлын хэсгийг гарч гарч, бүх л яам салбаруудаар явж байсан. Бүхий л байнгын хороод өөрсдөө ажлын хэсэг байгуулаад л, зарим нь ч хэрэгтэй л байсан байх, зарим нь ч их ажлын дунд, эд ажлын дунд яг үнэндээ садаа байсан юм. Тэр асуудлууд цэгцрэгдээд нэг хяналт шалгалтын хүрээ, Засгийн газар, бусад байгууллагуудтай харилцах хүрээ, хязгаарыг ингээд явах юм гээд ойлголт дээрээ бол бүгд нийлж байгаа гэдэгт би эргэлзэхгүй байгаа. Нэг талдаа бас зөв байх. Их Хурал орох, орохгүй юм руугаа ордоггүй нь гүйцэтгэх захирлын байгууллагууд нь өөрсдөө хийдэг юмаа хийдэг, шаардлагатай үед тэр тайлан төсөв төлөвлөгөөгөөрөө бол хяналтаа Их Хурал тавиад явчихдаг байхгүй. Бүхий л үед ордоо ороод л ажил яаж байна? тэр ажил яаж байна? гээд л араас нь явдаг нэг олон хаалгыг нь бас цөөлсөн нь бас үр дүнтэй гэж харж байгаа юм.

Би Сүхбаатар гишүүнээс нэг зүйл тодруулъя. Энэ хуулийн төсөл боловсруулах, өргөн барих үед би бас оролцсон л доо. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа асуудлаар хяналтын сонсгол явуулахыг хориглоно гэж заалт байсан. Энийг аваад хаячихсан. За нэг талдаа сайн ч байж магадгүй, энд бас нэг сөрөг тал байгаа. Шүүхийн шатанд явж байгаа хэргийг энд авчирч задлаад, хамаагүй л дээ, зүгээр энгийн хэрэг ярья. Төрийн аль нэгэн албан тушаалтан, өндөр албан тушаалтантай холбоотой хээл хахуул, авлигын байна уу, хэргийг авчраад сонсгол хэлбэрээр задлаад аль ч үгүй болгоод хаячихдаг.

Г.Занданшатар: Уучлаарай Раднаасэд гишүүнээ, асуултыг чиглүүлэхийн тулд тэр заалт хасагдаагүй байгаа шүү, тэрийгээ боловсронгуй болгох

Ш.Раднаасэд: Хасчихсан харин. 25.3 гээд. Энэ бол зүгээр саяынх энгийн жишээ шүү. Маш олон ийм асуудал гарч болзошгүй. Мөрдөн байцаалтын шатанд, прокурорын, хяналтын шатанд явж байгаа үед, эргээд энэ нь шүүх дээр дахиад энэ хэргийг шийдэх үед нээлттэй явж байгаа хяналтын сонсголд маш их хэмжээний тийм сэтгэлийн хөдлөл гэх юм уу, тийм үр дагавартай, нийгэмд гарна. Энд хэлж байгаа Их Хурал дээр хэлж байгаа хүн энд хариулт, тайлбар өгч байгаа албан тушаалтан, хяналтын сонсгол гэрчээр ирсэн хүмүүсийн үг өгүүлбэрээс хамаараад хүн буруутай юм байна, буруугүй юм байна гэдэг ийм дүгнэлтийг аль уже хийчихнэ нийгэм, тэрний дараа шүүх дээр асуудал яригдахад, нөгөө үнэ цэнэггүй болчихсон нотлох баримтууд яах вэ? Эсвэл бол гарах ёсгүй нотлох баримтууд гаргаад өгснийх нь төлөө нөгөө хэрэг чинь янз янзын байдлаар эргэвэл яах вэ гэдэг ийм болгоомжлол бас харагдаад байсан юм.

Анх энийг яг орчихсон байхад нь би бас зөв юм орчихсон байна аа, энийг бол бас байж байх юм чинь хэрэгтэй юм болов уу гэж харж байсан. Тэртээ тэргүй Улсын Их Хуралд хэрэгцээтэй гэвэл дотоод, гадаад аливаа асуудлаар юмаа аваад хэлэлцэх бүрэн боломжтой шүү дээ. Жоохон хязгаар юмыг нь тавьж өгөхгүй бол хэт их улс төржсөн, хэт их попрох гэдэг юм уу, тодрох гэсэн нэг ийм үзэл хандлага чинь аваачаад тодорхой зүйлүүдийг аваачаад, аль ч үгүй болгоод хаячих вий гэсэн ийм болгоомжлол байгаа юм. Хассан шалтгаан нь юу бодож хийгдээд хасагдчихав гэж л асуух гээд байна л даа.

Г.Занданшатар: За Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн хариулъя. Өөр нэг газар, нэг эрх бүхий байгууллага гээд заалт байгаа ш дээ.

Ж.Сүхбаатар: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Яг яах уу, Раднаасэд гишүүний асуудлыг бол ер нь Нямаагийн Энхболд гишүүн, Ц.Мөнх-Оргил гишүүн

нар бол ярьсан, Бид нар бол ажлын хэсгээс гадна, байнгын хорооны түвшинд бол хасъя гэж шийдсэн. За түрүүн Даваасүрэн гишүүн хэллээ шүү дээ, жишээлбэл ийм хэргүүд бол шийдэгддэггүй байхгүй юу.

Ингээд хууль хүчнийхэн өөрсдөө орооцолдчихсон, тэгээд л тэнд байж байдаг, асуудал нь шийдэгддэггүй. Тэгээд Чимид Үндсэн хуулийн эх баригч Чимэд багшийн ч гэсэн нэг яг парламентын шалгалтын чиглэлээр нийтлэл байгаа, яг тэн дээр бичсэн байж байгаа. Яг Зоригийн хэрэг шиг ийм хэргүүд бусад улс орнууд байхад 5, 10 жилээр шийдэгддэггүй. Парламентад татаж ирээд мөрдөн шалгалтаар асуудлыг нь яриад тэр асуудлыг шийдвэрлэх явцыг түргэсгээд шийдчихсэн байгаа байхгүй юу. Гэтэл энэ заалт бол тэрийг бүхэлд нь хааж байгаа заалт юм. Хэрвээ явчих юм бол цаашдаа Зориг хэрэг шиг ийм хэргүүдийг тэгээд л тэнд мөрдөн байцаалт нь байгаа гээд парламент нь сонсож чадахгүй.

Бид бол жишиг тогтчихсон байхгүй юу. Таны хэлдэг болгоомжлол дээр бол ийм байгаа. Ерөөсөө хянан шалгах түр хороог байгуулахад тэр шалгалт, мөрдөн шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг тэр тогтоолын төсөлд тодорхой тусгана. 19-өөс доошгүй гишүүн,энийг санаачлаад тэгээд Их Хурал дээр хүрээ хязгаарыг нь тогтооно. За дээр нь хуульд болохоор төрийн эрх мэдлийн, эрх мэдэл хоорондын тэнцвэрийг баримтална, шүүх эрх мэдлийг орлохгүй, За мөн хяналт шалгалтыг явуулж байхдаа хараат бус, бие даасан байгууллага болон хянан шалгах үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын үйл ажиллагаанд шууд хөндлөнгөөс шууд оролцохгүй бусад улс орнууд ингэж байгаа. Яг тэр шүүхийн шүүн таслах үйл ажиллагаа, мөрдөн байцаалтын үйл ажиллагааг бол шууд мөрдөн шалгалт сонсголд оруулдаггүй. Ямар хэрэг үү гэхээр тэр хэрэгт хамааралтай байгаа, зүгээр факт нөхцөл байдлуудыг тодруулж авч үздэг, ярьдаг, мэдээллийг авдаг, тодруулдаг, мэдээлдэг, тэгээд тэрний дагуу тэрийг шаарддаг, шахдаг. Энэ дээр бид нар болгоомжилж байна. Холилдоод орчих вий.

Бид нар дээр тэгээд цаашдаа ажиллахад хуулийнхаа аль аль талынхаа, хуулийнхаа ямар парламентынх нь соёл арга барилд суралцаад шинэ юманд суралцах ёстой байхгүй юу. Тэгэхгүй болохоор одоогийн заалт чинь бол ерөөсөө бүхэлд нь асуудлыг ингээд 100 хувь хаачхаад байгаа байхгүй юу. Тэгээд байнгын хороон дээр бид ярьж байгаад манай парламент 1 хүн дангаараа шийдэхгүй, 76-лаа ярьж байж түр хороог байгуулна, сэдвийг нь зааж өгнө, хүрээ хязгаарыг нь зааж өгнө, хуульд энд хутгалдаж орохгүй байх заалтууд нь байж байна. Тэгэхээр шүүх эрх мэдлийн ажлыг ингээд өөрөө авч орлон гүйцэтгэхгүй, шийдвэр гаргахгүй, гэм бурууг тогтоохгүй. Гол нь тэр факт нөхцөл байдлыг гэж байгаа юм.

Гол зорилго нь, энэ бол нотлох баримтыг цуглуулах, гэрчийг дуудах, шинжээч томилох, хянан шалгагч ажиллуулах замаар бол нөхцөл байдлыг ингэж гаргаж, гэм буруугийн биш нөхцөл байдлыг нь ингэж гаргаж тодруулж, ингэж ярьж асуудлыг парламентаас ингээд өөрийнхөө хүрээндээ авч үзэх ийм боломж нь бол нээлттэй байх үүднээс ингэж хийж байгаа юм. Болгоомжлолыг бол ойлгож байгаа, ажлын хэсгийн шатанд ч нэлээн ярьсан, байнгын хорооны түвшинд ч энийг ярьсан. Тэгэхдээ бусад улс орнуудад энийг хязгаарлачихсан гээд болохгүй шүү гэсэн юм бол байхгүй байгаа. Зүгээр Орост яг тэр шүүн таслах ажиллагаа болохгүй, мөрдөн байцаалтын ажиллагаа, объект нь болохгүй шүү гэж байгаа, гэхдээ тэр хэргийн нөхцөл байдал, баримтыг бол ярина шүү гэж, гэм буруу бол тогтоохгүй гэдэг ч юм уу? Англи-Саксоны орнууд, эд нар бол гэм бурууг нь тогтоочхож л байгаа юм л даа. Англи-Саксоны орнуудын юун дээр бол хагас шүүхийн үүрэг гүйцэтгэдэг учраас

парламент нь бол гэм бурууг нь хийгээд л, тогтоогоод л явчхаж байгаа. Манай яг Ром-германы системийн эндээ бол яг тийм маягаар явж байгаа.

Мөнхсайхан багш нэмж хэлэх үү, үгүй юу? бас нэлээн анхаарал татаж яригдсан учраас бид бас нэлээн ч ярьсан. Парламентаа бас энэ хуулийг гаргачхаад тэрийг нь хаачих юм бол ингээд хянан шалгах түр хорооны чинь ач холбогдол, үүрэг роль л бас их суларчих гээд байгаа байхгүй юу. Түрүүний хэлдэг ёстой нөгөө мөлийчих гээд байгаа заалт, томъёолол нь бол манай дээр гаргасан улсууд өөр олигтой томъёолол бас олдож өгөхгүй байна л гээд.../минут дуусав/

Г.Занданшатар: Мөнхсайхан доктор нэмж хариулах уу? Байнгын хороон дээр би юуг нь андуурсан байна. Энийг өөрчилж найруулаад санал хураахад бас дэмжигдээгүй юм байна. Сая сүүлийн байнгын хорооны хуралдаан дээр нэг Мөнх-Оргил гишүүн 1 санал гаргаад санал хураагаад дэмжигдээгүй шүү дээ тээ? Тэн дээр чинь иймэрхүү агуулгаатай заалтыг өөрчлөн найруулсан байсан. Дэмжигдээгүй юм байна. Би тэрийг дэмжигдсэн гэж бодсон юм. За одоо эрхэм гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: За баярлалаа, би түрүүн асуулт хариулт мэтгэлцээнийг анхааралтай сонслоо. Хуулийн төсөл бол сайн боловсруулагдсан, ажлын хэсгүүд бол сайн ажиллажээ. Энэ хууль батлагдсанаар Үндсэн хуульд заасан Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага хууль тогтоох Улсын Их Хурал маань хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, хэрэгжүүлж ажиллах ийм нөхцөл бололцоо бүрдэх нь гэж, ингэж үзэж байна. Тэгээд надад тодорхой 2 зүйл байгаа юм.

Нэгдүгээрт бол түрүүн Даваасүрэн гишүүн ч хэлсэн, илэрдэггүй олон арван жилээр сунжраад байгаа хэргүүдийг нэг талд нь гаргах. За түрүүн хэлсэн дээр нь нэмж нэг зүйл хэлэх гээд байгаа бол төрийн өндөр дээд албан тушаалтнууд, шулуухан хэлэхэд Ерөнхий сайдуудын, нэр бүхий улсуудын нийтийн эрх ашгийг хохироосонтой холбоотой асуудлууд байна шүү дээ. Зарим улсууд бол гадаад улс орноос ирж чадахгүй, гадаадад сууж байдаг, зарим нөхдүүдийн асуудал бол олон улсын шүүх, олон улс, дэлхий даяар дэлгэгдчихсэн ингээд байж байдаг. Хэрвээ хүний нэр хүнд, нэр төр, алдар хүндэд халдсан бол тэр гадаадын холбогдох байгууллагууд бол хариуцлагаа хүлээх ёстой.

Тэр байгууллагуудын нэр хүнд ямар түвшинд орох вэ? Би бол тухайлах юм бол эгэ хэрэг дээр хөөцөлдөж байгаа олон улсын шүүх, олон улсын шалгалтын тэр агентлаг байгууллагууд бол шууд зарчмаараа татан буугдаж дампуурах ёстой гэж би ингэж ойлгож байгаа юм. Тийм учраас нэгэнт асуудлуудыг гаргаад тавьчихсан бол тэр байгууллагууд өөрийнхөө нэр хүндийг бодох ёстой шүү дээ. Тэр ойлгомжтой асуудал. Тэгээд ийм мэтийн юмнууд Монголд орж ирээд, Монголын шүүх, хуулийн байгууллагууд руу шилжээд, ингээд таг хаагдчихсан.

Тэгээд энэ асуудлууд яах юм бэ? Ингээд энэний ард талаас зөндөө олон асуудлууд бий. Иргэд олон түмэнд чинь нээлттэй ярьж байна шүү дээ. Үгүй ээ, та нар минь ингээд л зөндөө олон, авлигал хээл хахуультай холбоотой луйвар, булхай нөгөө оффшор, гадаадын улс орнуудад хэчнээн тэрбумаар хаус, байшин, эдлэн авчихсан, бөөн сүр дуулиантай асуудал яригддаг. Тэгээд л таг намжчихдаг. Тэгэхээр Сүхбаатар гишүүн бол маш тодорхой ярьж байна л даа. Яг үүнтэй холбоотой асуудлыг бол хяналт шалгалтын хууль батлагдаад түр хороо байгуулагдаад асуудлыг бол яг тэр холбогдох факт баримт юу байдаг юм, тэр юмаар нь бол тодорхой гаргаж өгнө гээд ярьж байна шүү дээ.

Тэгээд энийг ингэж Их Хурал дээр нэг тал руу нь үнэхээр бодитой юм бол бодитой, тэрийг улс төрийн зорилгоор гүтгэсэн ийм асуудал байх юм бол энийг нэг хар цагаанаар нь ялгаад, гаргаад өгвөл аль аль талдаа амар байгаа байхгүй юу. Тэгээд чиглэлийн юман дээр хуульд ямар тодорхой зүйл байх вэ, иргэд олон түмэн бол энийг л хүсэн хүлээж байгаа юм. Тэгээд би 2 дахь хэлэх гээд байгаа юм. Бол нэг зүйл бол төрийн эрх ба барих дээд байгууллагад иргэдийг төлөөлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн хариуцлага хамгийн чухал юм. Тийм учраас Ёс зүй, сахилга хариуцлагын байгын хорооноос бид бол асуудлыг л тавиад байгаа шүү дээ. Харин сайшаалтай нь бол Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүйн дүрэмтэй холбоотой асуудал бол овоо эрчимтэй.../минут дуусав/

Г.Занданшатар: За эхлээд Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн ажлын хэсэг хариулъя.

Ж.Сүхбаатар: За тэгэхээр эрхэм гишүүн Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Таны хэлдэг үнэн л дээ. Яг нийгмийн дуулиан шуугиан л болоод байдаг. Тэгээд л тэр асуудлыг нь манай тэр гишүүн, гишүүн нь тэгэх хэрэгтэй байна гээд гадна талд нь бас тэгэх хэрэгтэй байна гэдэг. Тэгэхээр нийтийн ашиг сонирхлыг хөндсөн олон нийтийн дунд санаа зовоосон, тайлал байхгүй. Ийм байгаа юмыг цэгцэлдэг, янзалдаг албан ёсных нь индэр болдог юм уу даа.

Олон нийтийн өмнө нээлттэй тайз болдог нь парламентын мөрдөн шалгалтын асуудал байгаа юм. Тэгэхгүй тэнд нэг мөрдөн шалгалт хийж байгаа нөхдүүд гээд байгаа улсууд нь бол нууц мөрдөн шалгалтын нууц дандаа далд, хаалттай хэлбэрээр явдаг өмгөөлөгч, оролцогч талууд нь хязгаарлагдмал хүрээнд, парламентын мөрдөн шалгалтын гол үндсэн үйл ажиллагаанууд нь бол ил явагддаг байгаа материалуудыг татаж авдаг, цуглуулдаг танилцуулдаг. Тэгэхээр хянан, шалгах хорооны түр хорооны тайлан гэж гардаг. Бусад улс орнууд ерөөсөө парламентаа яаж хөгжүүлсэн байна вэ гэхээр янз бүрийн тэр зүгээр ажлын хэсгийн биш ийм комиссууд гараад ажиллаад, тайлан гаргаад тэр тайлангийн үндсэн дээр хариуцлага тооцдог.

Тэр тайлангийн үндсэн дээр хууль тогтоомжоо боловсронгуй болгоё, тэр тайлангийн үндсэн дээр шахаж шаарддаг, тэр тайлангийн үндсэн дээр иргэдийг мэдээлэлжүүлдэг, тэр тайлангийн үндсэн дээр за төрийн албан тушаалтнуудын хийх ажлаа мэдэж авдаг. Ийм юм бол албан ёсны механизм юм байна. Бид бол ажлын хэсгийн хүрээнд ярьдаг. Гэтэл яг сая таны хэлдэг санаа зовоосон янз янзын ярьж байгаа асуудлуудыг нэг ажлын хэсэг гаргадаг, тэгээд тэр ажлын хэсэг нь яасан ч юм, заримдаа нэг юм гаргаад ингээд танилцуулаад яах вэ ер нь бол сүүлийн жилүүдэд бол манай ажлын хэсэг болон түр хороо, эд нар бол ажил нь бол сайжирсан уу, сайжирсан.

Сүүлийн 2,3 жилийн хугацаанд юм бол өөрчлөгдсөн. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт орохтой холбоотой, орсны дараа. Тэгэхээр асуудлууд дээр бол өөрчлөлт гарна. Түрүүн Раднаасэд гэдэг гишүүний хэлдэг ч асуудал байж байгаа. Ерөөсөө бид нарын бүх юм бол яг хууль гарчихаар ингээд нэг албан ёсны тодорхой юмнуудтай болчихож байгаа байхгүй юу. Хуулийн заалтыг бариад л болно болохгүй, энэ чинь бол хууль дээр ингэж заасан байна гэж яг тодорхой барих юмтай байхгүй юу. Түрүүн Бямбацогт гишүүн ч гэсэн хэлж байна. 1 л бүлэг байсан шүү дээ. Тэгэхэд чинь 4 бүлэгтэйгээр 60-аад зүйлтэй нааш, цааш хөдлөөд ингээд ийм хэмжээний тээ? Энд чинь 7 бүлэг байна, тийм 7 бүлэг 58 зүйл болчихсон явж байгаа юм.

Тэгэхээр ийм том хэмжээний ингээд хууль болчихсон. Анхдагч хууль байж байгаа. Анх удаа гарч байгаа. Тэгэхээр яг таны саяын хэлдгээр ер нь бол манайхны нэг буруу хандлага байсан юм. Парламент хууль тогтоочихсон юм чинь гал аваад яах юм бэ гээд ард түмний төлөөлөгчдийн байгууллага өөр дээрээ тэр олон түмний дунд үүсээд санаа зовоож байгаа тэр асуудлуудаа шийдэл гаргахгүй, ингээд түлхээд байхаар шийдэлгүй болчхож байгаа юм. Тэгээд хүмүүсийн цөхрөл, бухимдал, шүүмжлэл гадна талд үүсч байгаа юм. Хариуцлагаа үүрсэн шиг үүрнэ гээд орж ирсэн улсууд, төлөөлөгчдийн байгууллагын танхим дугуй танхим дотроо асуудлаа ярьж, ойлгуулж, мэдээлэл дутуу бол дутуу байгааг нь ард түмэнд харуулж, мэдээлэл шаардлагатай бол авахыг нь авч хариуцлага тооцож чадахгүй байгаа бол хар, тооцож чадахгүйгээ харуулж байгаа, тэгээд аль аль нь бие биеийнхээ шахалт шаардлагын тулд нээлттэй ийм индэр болж ажиллах ёстой байгаад байгаа юм бол зүгээр нэг шоу биш.

Тэгэхээр яг тэр гаднын орнуудын тэр жишиг стандартаар нь энийг оруулж өгсөн, тэгээд шинэ юм болохоор болгоомжлол их байгаа. Тийм учраас болгоомжлол дагаад бас мөлийлгөчихлөө гээд байгаа тал байгаа гэж сануулаад байсан. Тэгээд аль болохоор яах вэ, ойлголцож ажилласан, манай ажлын хэсэгт байгаа Мөнх-Оргил гишүүн, Тогтохсүрэн, Нямаагийн Энхболд гишүүн, тэгээд Адьяасүрэн гишүүн гээд бүгд л маш олон санал хэлсэн. За ер нь бол ажлын хэсгийн ахлагчийн хувьд дашрамд хэлэхэд саналаа өгсөн гишүүдэд их баярлаж байгаа. Тэдний саналыг ер нь бол 95 хувийг нь бол би авчихсан гэж үзэж байгаа бол зөвшилцөл ойлголцол, туршлагатай хүмүүсийнхээ санаа оноог ч гэсэн бас тусгасан гэж хэлмээр байна.

Г.Занданшатар: За болно, болно, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: За баярлалаа. Их тодорхой хариулт өгсөн явдалд. Тэгээд би цаг багтаагүй учраас үргэлжлүүлээд 1 минутдаа, 2 зүйл хэлээдэхье. Тэгэхээр хамгийн гол нь ялангуяа төрийн өндөр дээд ажил, алба хариуцаж байгаа хүмүүс. За түүнчлэн ард түмний төлөөллийн байгууллагад, иргэдийнхээ итгэл мандатыг өвөртөлж орж ирсэн ийм хүмүүс ямарваа нэгэн асуудалд холбогдох юм бол тэрийгээ бүр хар, цагаанаар нь тэр өөрийг нь нэр дэвшүүлсэн улс төрийн байгууллага дээрээ улс төрийнхөө тэр байгууллагын юугаар байдаг юм уу, Тэгэхдээ олон түмэнд ил тод нээлттэй Их Хурал дээрээ тэр ёс зүй хүрээнд байх юм уу? Мухарладаг ийм зарчмынх нь юмыг хяналт шалгалтын хууль дээр тийм орсон зохицуулалт байх уу? Тэгэхгүй бол ингээд сүүлд яригдаад байгаа юм бол ерөөсөө гүтгэсэн байх юм бол тэрийгээ хар, цагааныг нь ялгуулж шүүхэд хандаж .../минут дуусав./

Г.Занданшатар: За эхлээд хариулчхаад дараа нь ахиад 1 минут өгий. Мөнхсайхан доктор 80,

О.Мөнхсайхан: Уучлаарай, Бат-Эрдэнэ гишүүн, бусад гишүүд маань маш чухал. асуудал хөндөж байна. Тэгэхээр ер нь бол дээр яг тодорхой зүйл нь шалгагдаж байгаа Эрүүгийн хэрэг, хянан шийдвэрлэх ажиллагаанд ер нь оролцох юм уу? үгүй юу? энийг бүр нээх юм уу, хаах юм уу? гээд дээр бол олон талаас нь яригдаж байгаа, тэгээд өргөн баригдсан төсөл ч тэр, одоо явж байгаа эцсийн найруулга дээр ч тэр, ерөнхийдөө бол балансыг нь олох ийм байж болох л гаднын улсын туршлага, дотоодынхоо онцлогийг харгалзсан ийм зохицуулалтууд орсон. Тэгээ дээр бол жишээ гэвэл түрүүн Сүхбаатарын гишүүн дурдлаа. Чимэд багшийн

яг 10 жилийн өмнө парламентын хяналт шалгалт огт явахгүй, үүргээ гүйцэтгэж .../минут дуусав./

Г.Занданшатар: Гүйцээж хариулъя, 80, 82 уу? За 80.

О.Мөнхсайхан: Хянан шалгах, ялангуяа мөрдөн шалгах бүрэн эрхтэй энэ хяналтын функц байхгүй байна гэдэг асуудал гарч ирсэн. Тэгээд гаднын жишээ нь бол "Энрон" компаниас бол бүгд найрамдахчуудын санд хууль бус хандив өгсөн Кол-ийн хэрэг гэх мэтчилэн ийм ноцтой хэргүүд бол парламентын хяналт шалгалтын явцад яагаад явахгүй байгаа шалтгаанууд ил тод болсон жишээг аваад тэгээд Зориг агсны хэрэг банк дампуурсан хэргүүд, иймэрхүү асуудлууд дээр парламентын хянан шалгалт учир дутагдалтай байна гэдэг зүйл яригдаж байсан.

Яг одоо бол жишээ нь Германд Бундистаг-т 3 ийм хянан шалгах түр хороо ажиллаж байгаа. Нэг нь бол террорист халдлагын асуудлаар үүссэн мэдээж тэндээ бол ингээд эрүүгийн хэрэг бол үүсчихсэн явж байгаа юм. Гэхдээ парламент нь бол ийм түр хороо байгуулаад яагаад ийм халдлага гарав аа? Ийм гэмт хэрэг гарав аа, шалтгаан нөхцөл юу вэ? хариуцлага алдсан уу тээ? Цаашдаа ийм юм гарахаас яаж урьдчилан сэргийлэх үү? гэх мэтчилэн асуудлыг ингээд цогцоор нь судалж байгаа зүйл байна. Дампуурлын асуудал байна. Тэгэхээр ерөөсөө хянан шийдвэрлэх ажиллагаа дээр байгаа асуудлаар хянан шалгах түр хороо байгуулахгүй гэхийгээр саяынх шиг зүйл рүү огт орохгүй, ийм хаалт үүсгэчихэж байгаа юм.

Дээрээс нь 2 сарын өмнө хууль зүйн байнгын хорооны хүний эрхийн дэд хороон дээр бас сонсгол хийсэн. Тодорхой иргэдийг хуулийн үндэслэлгүй баривчилсан уу, үгүй юу гээд. хэрвээ түрүүчийнх шиг хориглосон заалт орчихвол жишээ нь тэр сонсгол хийх боломжгүй л болчихож байгаа байхгүй юу. тэгэхдээ нөгөө талаас гишүүдийн санаа зовж байгаа асуудлыг бас харгалзсан 5 янзын хамгаалалтын механизм орсон байгаа.

Төслийн 4.2.3 дээр гүйцэтгэх эрх мэдэл болон шүүх эрх мэдлийг бол парламентын хяналт шалгалт орлон гүйцэтгэхгүй гэж байгаа. За 2-т хянан шалгах түр хороо бол төслийн 33.10-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс оролцох, заавар чиглэл өгөхийг хориглоно гэж заасан. За төслийн 56.4 дээр хянан шалгах түр хорооны тайлан, санал дүгнэлт нь шүүхэд ямар нэгэн үүрэг хүлээлгэхгүй гэж заасан.

Нөгөө талаар түрүүн бас дурдагдаж байна. Түр хороог байгуулахад шүүх эрх мэдлийн гүйцэтгэх эрх мэдлийн тэр асуудал руу орж байх юм бол үндсэн хуульд харшилсан гэж үзээд тэр асуудлыг хасах байдлаар Их Хурал тогтоолоороо гарах боломжтой. Тухайвал тодорхой этгээдэд хариуцлага тооцох, гэм бурууг тогтоох, ял шийтгэл оногдуулах бол Улсын Улсын Их Хурлын ажил биш, Үндсэн хуулийн шүүх эрх мэдлийн асуудал учраас саяынх шиг асуудал руу шууд орох нь бол Улсын Их Хурал үндсэн хуулиа зөрчсөн байдал руу орно. Тэгэхээр дээр бол Их Хурал хяналт шалгалтаа явуулахдаа хянаж харгалзаж үзэх ийм боломж болсон. Тэгэхээр бол яг судалгаагаар ингээд гарч ирж бас гишүүд бол олон талаас нь асуудлыг бол ерөөсөө өргөн барихаас өмнө жил хагас ярьсан сүүлийн жил, хагас жилийн хугацаанд бол ярьж байгаад балансыг нь олсон ийм зохицуулалт гарч ирсэн байгаа.

Цаашид бол яг хууль өөрөө чинь анх анхдагч хууль учраас хэрэгжээд ирэхээр тодорхой зүйлүүд үүсэх юм бол эргээд хууль тогтоомжоо сайжруулаад явах ийм бүрэн боломжтой. Ер нь хууль маань бүхэлдээ харах юм бол бүүр мөлийгөөд ингээд

байхгүй болсон юм бол байхгүй. Одоогийн Монголын нөхцөл бас үүсэж болох эрсдэл болгоомжлол эд нарыг бол маш сайн тусгасан. Нөгөө талаар олон улсын сайн туршлагаас бас авч болох зүйлүүд орсон байгаа. Тэгэхээр судлаачийн хувьд бол энэ хууль батлагдан гарснаар парламентын хяналт шалгалт бол шинэ түвшинд гарна гэж харж байгаа юм.

Ялангуяа энэ дээр бол тэр Улсын Их Хурлаас томилдог, зөвшилцдөг танилцдаг, тэгээд бие дааж ажиллах тэр байгууллагуудын байгууллагын албан тушаалд нэр дэвшигч дээр бол нэр дэвшигчийн сонсгол хийх маш нарийн цогц зохицуулалт орж ирж байгаа учраас дээр бол харьцангуй сайн нэр дэвшигчид гарах процедурын баталгаа бол тодорхой хэмжээнд бүрдэж байгаа. Гэхдээ маань яаж хэрэгжүүлэхээс, бас мэдээж яг ямар хүн томилох вэ гэдэг нь харагдана. Нөгөө талаас хянан шалгах түр хороо бол цоо шинэ институт байж байгаа. 3-т бол юу вэ гэхээр бас парламентыг үл хүндэтгэхтэй холбоотой .../минут дуусав./

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн нэмэлт 1 минут асууя. Яаж өөрчилснөө Сүхбаатар ажлын хэсгийн дарга танилцуулчих.

Б.Бат-Эрдэнэ: Би хэлэх гээд байгаа нь бол ерөнхийдөө нэг ийм зарчим байна шүү дээ. Шатыг бол дээд талаас нь шүүрдэнэ гэж доод талын гишгүүрээс нь шүүрдээд бол үр дүн гарахгүй гэж. Тийм учраас бол төрийн эрх барих дээд байгууллага ард түмний элч төлөөлөгч болсон энэ байгууллагаас, энэ байгууллагад ажиллаж байгаа хүмсээс л эхлэх ёстой гэдэг л ийм юм хэлээд байхгүй юу. Гэтэл бол ямар юм яваад байгаа вэ гэхээр зэрэг бид ардчиллыг авчирсан, бид эрх чөлөөг олгосон чамайг, намайг гүтгэх эрх чөлөөг би чамд олгосон гэж хэлээд тэгээд яаж ч гүтгэж байсан болно.

ШыйгүүнхэнххмсөчТэр гүтгэлгийн хариуд бол үг хэлэх, ямар нэгэн хариу тайлбар өгөх эрх байхгүй гэж хуулиар хааж өгөөд, тэгээд тэрнийхээ ар талд хамаг муухай луйвар, булхай юмнуудаа хийгээд сууж байгаа улсууд чинь энд байгаад байгаа байхгүй юу. Тийм учраас талаас нь ямар юм байх юм бэ?

Г.Занданшатар: За Сүхбаатар гишүүн хариулъя ажлын хэсгийн дарга Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: За гишүүний тэр хэлээд байгаа асуудлыг би ойлгож байна. Жишээлбэл Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хууль гарахад юу хийж болох юм бэ гэж. Тэгэхээр төсөл, хуулийн төслийн 28.1-т Улсын Их Хурал хуулийн 14 зүйлд заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагавартай танилцах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх зорилгоор ерөнхий хяналтын сонсголыг явуулна гэж байгаа. Тэгэхээр ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой асуудлаар гэхэд ерөнхий хяналтын сонсголыг жишээлбэл ингээд хийнэ гэсэн үг.

Тэгээд тэр үйл ажил өндөр албан тушаалтнуудын үйл ажиллагааг хяналт тавих хүн л зүгээр. Яг Улсын Улсын Их Хурлын гишүүдийн асуудал гэхээр энэ Улсын Улсын Их Хурлын хяналт шалгалт учраас яг улсын Их Хурал, Улсын Улсын Их Хурлын гишүүдийн хийх гэж байгаа ажил учраас яг гишүүдэд өөрт нь ёс зүйн үнэлгээ дүгнэлтийн асуудлыг бол бид ёс зүйн дүрмээр тусад нь бол бусад улс орнуудын жишгээр яг өөрийн гэсэн тийм тогтоолын хэлбэртэй, парламентийн юутай тийм.

Г.Занданшатар: Парламентыг үл хүндлэх гэдэг заалт орсон. Түрүүн Даваасүрэн гишүүний хэлснээр асуултад дутуу хариулах юм уу, парламентын үйл ажиллагаанд худлаа хариулах юм уу, хариулахгүй зайлсхийх учир шалтгаангүй ирэхгүй байх ч гэдэг юм уу, гэрчээр дуудахад. Нээлттэй сонсголын бусад арга хэмжээнд хууль журам дагаж мөрдөхгүй бол парламентыг үл хүндэтгэх гэсэн ийм санкцаар эрүүгийн хэрэг үүсгэхээргүй бол захиргааны шийтгэл оногдуулахаар, Төрийн албаны хуульд заасан ч шийтгэл оногдуулахаар заасан зохицуулалттай болсон.

2-рт нь ийм байгаа шүү дээ. Ер нь шатыг дээрээс нь шүүрддэг гэж Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн маань хэлдэг. Ёс зүйн асуудлаар ингээд хэл ам, шуугиан байдаг, тэр нээлттэй сонсгол хийгээд асуудлыг засах болно. Сая Мөнхсайхан доктор хэлээд байгаа бол парламент бол мэдээж шүүх үүргийг гүйцэтгэхгүй Үндсэн хуулийн дагуу, гэхдээ бусад улсуудын үндсэн хууль болон ийм хяналт шалгалтын хуульд бол нотлох баримтыг шүүхэд даалгавар өгөхгүйгээр хүргүүлж болно гэсэн. Энийг үнэлж өөрсдөө шийдвэрээ гаргаа гээд хууль сахиулах байгууллагууд болон шүүхэд хүргүүлж, шийдвэр гарахад нөлөөлж байна.

Энэ яагаад гэхээр хууль сахиулах байгууллагууд төрийн өндөр албан тушаалтнуудыг дуудаж асууж хэрэг үүсгэж, ингээд янз бүрийн шалтгаануудаас чаддаггүй бол сөрөг хүчний оролцоотойгоор хуулийг биелүүлэх асуудлаар энийг байгуулна гэдэг маань улс төрийн маш том хяналтын механизм байгуулж байгаа учраас манай авилгийн индекс энэ хуулийг баталснаар урагшаа нэлээн хэдэн оноогоор ахина, авлигатай тэмцэх үйл явдалд том ахиц дэвшил гарна гэж итгэж байгаа юм. Улсын Их Хурал хүний эрхийг хамгаалагчийн тухай хууль баталсан учраас сая дэлхий дээр ганцхан Монгол Улсын хүний эрхийн үнэлгээ урагшиллаа.1 оноогоор нэмэгдээд урагшилсан. Тэр дээрээс сая ардчиллын их хурал дээр тэмдэглэсэн байлаа.

Ганцхан Монгол Улс бол хүний эрхийн асуудлаар урагшаа ахисан. Учир нь хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлыг бий болгосон, хүний эрхийг хамгаалагчийг, тэгээд хүний эрхийн талаар хийж байгаа парламентын ажлууд бас тодорхой үр дүнд хүрээд байгаа. Тэгээд авлигатай, авлигын индексийг зориуд бууруулна гээд том зорилт тавьчихсан, авлигатай тэмцэнэ, зорилт тавьчихсан, хууль бол маш чухал дэвшил авчирна. Яагаад гэвэл цөөнхийн төлөөллийг оролцуулаад парламентын хяналт гэдэг бол маш том хяналтын механизм болно гэж хууль санаачилж хэрэгжүүлсэн.

Манай С.Бямбацогт, Ж.Сүхбаатар нарын гишүүд Ц.Даваасүрэн гишүүн ч гэсэн өөрөө хууль санаачлагч ажлын хэсэгт ороод ажилласан. За ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа зарчмын зөрүүтэй саналын томилолтоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 23 санал байгаа. За санал хураалтад бэлтгэе. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

За 1.1 чуулганы нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулах чиглэл, өгсөнтэй холбоотой саналын томъёолол.

1.Төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах: “22.4.Энэ хуулийн 22.2-т заасан дүн шинжилгээ, 22.3-т заасан дүгнэлтийг харгалзан шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал нэг дэх хэлэлцүүлгээс төсвийн төслийг Үндсэн хууль, холбогдох хуульд нийцүүлэх чиглэл

өгч зөвхөн нэг удаа Засгийн газарт буцаана.”.Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо,

За санал хураалт. Бейсен, Ганибал гишүүнийг дуудчих.За 52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 29 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах, 29 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсгол. 29.1.Эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас дараах нэр дэвшигчийн сонсгол явуулна.

29.1.1.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Авилгатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Ерөнхий аудитор, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, Үндэсний статистикийн хорооны дарга, Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргын албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсгол;

29.1.2.Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол явуулахаар хуульд тусгайлан заасан, эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.

29.2.Нэр дэвшигчийн сонсгол нь баримт, мэдээлэлд үндэслэсэн, талуудын оролцоог тэнцвэртэй хангасан байх бөгөөд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуульд заасан бусад шаардлага хангасан эсэхийг нээлттэй хэлэлцэж, олон нийт нэр дэвшигчийн талаар мэдэх эрхийг хангахад чиглэнэ.

29.3.Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ явуулна.

29.4.Нэр дэвшигчийн сонсгол явуулахад энэ хууль, Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

29.5.Байнгын хорооноос нэр дэвшигчийн сонсгол /цаашид энэ бүлэгт “сонсгол” гэх/ явуулах үйл ажиллагаанд Тамгын газар мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

29.6.Нэр дэвшигчийн дэлгэрэнгүй танилцуулга, томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, тухайн албан тушаалд тавих нийтлэг болон тусгай шаардлага зэрэг мэдээллийг авах маягтын загварыг холбогдох Байнгын хороо батална.

29.7.Энэ хуулийн 29.6-д заасан загварт дурдсан мэдээллийг нэр дэвшигчээс өөрөөс нь гаргуулна. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. 24 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.2.Сонсголд холбогдох Байнгын хорооны гишүүдээс гадна Нийтийн сонсголын тухай хуулийн 10.2-т заасан оролцогчид оролцох бөгөөд тус хуулийн 15 дугаар зүйлд заасан нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. Бусад байнгын хорооны гишүүд оролцохгүй хайчив. 23 гишүүн дэмжиж 57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.1.Түр хороо 5-19 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Улсын Их Хурлын гишүүн нэгэн зэрэг хоёроос илүүгүй түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллаж болно.” Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. 5-19 гэж яагаад болчхов уу? Үндсэн хуульд 19-өөс дээш гэж байх ёстой шүү дээ. Мөнхсайхан, доктор. За 80.

О.Мөнхсайхан: За тэгэхээр саяын заалт маань бол юу вэ гэхээр Үндсэн хуулийн 28.2-т зааснаар Улсын Улсын Их Хурлын гишүүдийн дөрвний нэгээс доошгүй нь бол санаачилбал хянан шалгах түр хороог заавал байгуулах зохицуулалт бол хэвээрээ байгаа. Үндсэн хууль дээрээ ч бас төслийнхөө урд бол байж байгаа. Сая уншсан 34.1 бол юу вэ гэхээр өргөн баригдсан төсөл бол түр хорооны бүрэлдэхүүн нь хэдэн гишүүнтэй байх юм бэ гэдэг дээр 19 хүртэл байна гэсэн ийм зохицуулалттай, өргөн баригдсан түрүүчийн удаа нэгдсэн хуралдаан дээрээс бол гишүүдээс гарсан санал бас Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу доод хязгаар нь хэд байх юм бэ? гэдэг орвол хэрэгтэй байна гэсэн ийм асуудал яригдсан.

Тэгээд ажлын хэсэг дээр бол ярьж байгаад доод хязгаар нь бол хянан шалгах түр хороон дээр 5, дээд хязгаар нь 19 байна гэдэг. Дээд, доод гишүүдийн тооны хязгаар бол дээр тавигдсан байгаа. Ер нь бол бусад улсын жишээ. Ингээд харахаар ерөнхийдөө 7 эсвэл 9-өөр байгуулдаг юм байна лээ. Германд яг ажиллаж байгаа 3 ийм хянан шалгах түр хороо бол 9, 9-н гишүүнтэй, тэгээд тэн дээр олгох цөөнхийн төлөөллийг хангачихсан ийм байдлаар бол байж байгаа юм байна даа. Тэгэхээр манай орж байгаа зохицуулалт бол бас ерөнхийдөө тэр гаднын туршлага, манай практик хууль тогтоомжийн хүрээнд бол оновчтой ингэж тодорхойлогдсон байгаа гэж харж байгаа. 19-өөс дээш бол байх боломжгүй энэ маань нөгөө байнгын хорооноос олон гишүүнтэй түр хороо гэж бол байх боломжгүй гэсэн ийм зүйл яригдаж тэгээд томъёологдоод орж ирсэн байгаа.

Г.Занданшатар: Үндсэн хуулийн 28.2 чинь хуулийн бэлтгэлийг хангахтай холбоотой, нийтийн эрх ашгийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна гэж зааж байна. За энийг бол 19-өөс доош байж болно гэж үзэж байгаа юм байна даа. За санал хураалт. 51.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсгийг хасаж, төслийн дугаарыг өөрчлөх санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Тэгээд яах вэ. Түрүүнийх дээр бол практик дээр тэгээд 19 хүн гарын үсэг зурчхаад, 5 хүн орохгүй л дээ, 19-тэй л тулж таарна гээд л тийм. За Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн. 36.6 дээр дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Энэ түр хорооны хэсэг дээр би түрүүнийх дээр уул нь нэг юм тодруулчихъя гэж байсан явчихлаа л даа. Би бол хууль санаачлагчид нь орж байгаа бол ажлын хэсэгт байгаагүй юм. За ажлын хэсэг дээр нэг ийм юм болчихсон юм, тэгээд тэрийг би босгоод явбал яасан юм л гэж болоод байгаа юм л даа. Саяын даргын яриад байгаа нөгөө ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар бид нар ингээд түр хороо байгуулагдаж байгаа дотор хуулийн төсөл санаачлагч юу гэж үзсэн гэхээр мөрдөн шалгах арга хэрэгслээр гэсэн байхгүй юу. Энэнээс ингээд айгаад энийг байхгүй болгочхоод байгаа байхгүй юу даа, энд попрод байх юм байхгүй ээ.

Манайхан зарим нь ингээд хүчний байгууллагынханд их долигонох юм. Өөрсдийнхөө хэрэг мэргийг дарах гэдэг юм уу, яадаг юм. Хүчний байгууллагыг чинь жоохон хязгаарлаж явах юм чинь бидэнд байх ёстой байхгүй юу. Бидэнд байх ёстой. Би тэр нөгөө жидүүг ингээд л харж байхад яг тийм л юм байна лээ, манайхан бол маш олон яснууд нь холбогддог. Тэд нар айдаг, дарамтлуулдаг, үг хэлж чаддаггүй. Тэгээд ингээд айгаад мөрдөн шалгах гэхээр л тэрийг нь авч хаяад л. Яагаад?нийтийн эрхийг, бүх хэргийг бид нар үзье гээгүй шүү дээ. Дараад байгаа, удаагаад, буцаагаад байгаа, шүүхээс доошоо орж ирээд байгаа энэ чинь, бөмбөгдөөд л 2, 3 жил, шалгах хугацаа дуусчихлаа, хөөн хэлэлцэх хугацаа дуусчихлаа гээд л хаячхаж байгаа шүү дээ. Хүний эрх, ашиг хохирч байгаа. Тэнд хэн худлаа шалгаж байгаа, энэ бүгдийг л хяная гэж байна шүү дээ. Мөрдөн шалгахгүйгээр яаж хянах юм? Би түрүүн хэлсэн шүү дээ. Хууль хүчнийхэнтэй холбогдолтой хэргийг зүгээр л прокурор дардаг юм байна лээ. Усанд хаясан чулуу шиг.

Тэгээд тэд нарыг хэн шалгах юм. Манайхан битгий тэд нарт тал засаад бай. Хэрвээ их тэгэх юм бол би нэр зааж хэлнэ шүү. Эд нартай холбогдоод байгаа улсуудыг, эд нарыг хэн хязгаарлах юм. Бид л хязгаарлана шүү дээ. Дураараа дургисан хэдэн хүн бий шүү дээ. Үгүй Тэгээд хүчний байгууллагуудын авлигын тухай ярьдаг мөртөө яагаад тэднийг илрүүлэх талаар нь ярьж чадахгүй байгаа юм. Тэд нар өөрсдөө авлигач байх юм бол яаж нийгэм цэвэрших юм. Тэд нарыг шалгахгүйгээр яаж авлигачийг нь илрүүлэх юм. Мөлийлгөж болохгүй шүү дээ. Тэнд попрор юм байхгүй. Тэднийг илрүүлэх тухай ярьж байна энд, илрүүлэх ёстой шүү дээ. Өөрсдөө тэнд суучхаад. Тэгээд би түрүүн 1 хэрэг хийсэн шүү дээ. Шууд л дарсан шүү дээ. Хууль зүйн сайдад нь өгсөн, ерөнхий прокурорт нь өгсөн, усанд хаясан чулуу шиг дарсан байхгүй юу 2 хэргийг, тэрийг чинь болиулъя гээд байна шүү дээ. Яагаад тэд нарыг шалгаж болдоггүй юм, тэд нар юу юм, тэд нар гэмт хэрэг хийж болох ёстой юм уу, тэрийг яаж хязгаарлах юм бэ гэдэг тухай л би яриад байна шүү дээ.

Тэгэхээр ингээд мөрдөн шалгах гэдэг үгийг нь авч хаяад л зөвхөн тэд нар мөрдөн шалгах эрхтэй, тэд нар гүйцэтгэх ажиллагаа явуулах эрхтэй гээд л, ингээд л. Нөгөөдөх нь улс төрчдийн дураараа утсыг нь чагнана, дураараа янз бүрийн мэдээллийг хоорондоо хэвлэл дээр элдвээр тэр мэдээллээ ашиглаж юм явуулна. Хүчний байгууллагууд чинь хэрээс хэтэрчхээд байна шүү дээ. Энийг чинь л хумья гэж байна шүү дээ. Ард түмнийг, бүгдийг чинь тэр хүний эрхийн асуудлыг чинь

уландаа гишгэж байгаа улсууд хаана байна, тэнд л байна шүү дээ. Тэрийг чинь болиулъя гээд байна шүү дээ. Шударга болгоё гээд байна шүү дээ. Улс төрчдийн хэргийг чадахгүй, тэгээд ирэнгүүт энийг нь аваачаад аваад хаячхаад байгаа байхгүй юу, нэлээн хэдэн мөлийсөн гишүүд аваачиж тэр ажлын хэсэгт оруулсан байгаа байхгүй юу л гэсэн. Манайд нэг мөлгөр юмнууд байдаг байхгүй юу даа. Тэгээд аваачаад ингээд хууль мөлийлгөөд, мөрдөн шалгах гэдэг үгийг нь, Улсын Их Хурлын дарга чиглэл өгөөд энийг буцааж босгоо.

Г.Занданшатар: Одоо хураах гэж байгаа санал бол 36.6 өөр санал л даа. Мөрдөн шалгах гэдгийг чинь би анхдугаар хэлэлцүүлэг дээр яг наад юмыг чинь зөндөө ярьсан. Тэгээд санал хураалтад дэмжигдээгүй. Тэр битгий хэл түр хороог мөрдөн шалгах гэж нэрлэхгүй бол мөрдөн шалгах сонсгол явуулж л байх байхгүй юу. Investigating public hearing гээд байж болох юм гэж. Тэгээд яриад бол, тэгээд яахав ингээд эцсийн хэлэлцүүлэгт орчихсон. Эцсийн хэлэлцүүлэг дээр 36.6 бол 36.6 дахь хэсгийг хасаж төслийн дугаарыг өөрчлөх гэсэн санал хураалтаар санал хураалт явуулна. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо, тэгээд ажлын хэсгийн дарга Сүхбаатар гишүүний тайлбарыг бол дараа нь өгнө биз. Одоо бол дэмжсэн, дэмжээгүй л үг хэлэх учраас.

За санал хураалт. Одоо ямар ч байсан хуулиа. Ажлын хэсэг бол байнгын хорооноосоо гарсан, байнгын хорооны ажлын хэсэг нь ажилласан. Тэгээд ингээд өөрчилчихсөн. Тэгэхдээ муужруулаагүй л гэж хэлсэн шүү дээ. Энэ заалт уначихаар чинь нөгөө түр хорооны чинь түрүүний бүрэлдэхүүнтэй чинь холбоотой 36.6 чинь. Төслийн дугаарыг өөрчлөхийг найруулга дээр янзал. Юу гэнэ ээ? Энэ найруулгын санал байна. Найруулгын санал дээрээ хэлэлцэж болно. За цаашаа явъя. Төслийн дугаарыг өөрчлөх гэж байгаа юм чинь. Дараа найруулгын саналтай давхцаж байна лээ. Энэ хууль чинь байхгүй болно л доо. 36.6-г хасахаа яах юм? Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: За би дарж амжсангүй даргаа, дахиад санал хураалгая.

Г.Занданшатар: За Бадарчийн Жаргалмаа гишүүний саналаар өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулна. Санал хураалт 23 гишүүн дэмжиж 59 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Горимын санал дэмжигдсэн учраас 5 дугаар асуудал буюу төслийн 36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсгийг хасаж төслийн дугаарыг өөрчлөх саналыг дахин хураалт явуулаа. Санал гаргасан. Төрийн байгуулалтын байнгын хороо. 24 гишүүн дэмжиж, 61.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 37 дугаар зүйлийн 37.2, 37.3, 37.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.2.Түр хорооны гишүүн гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах тухай тогтоолын төсөл санаачилсан бол тухайн асуудлыг түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Санал хураалтаар цөөнх болсон гишүүн тухайн асуудлаар үндэслэлээ дэлгэрэнгүй тайлбарлаж, 3 хүртэл удаа санал хураалгаж болно.”Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. 22 гишүүн дэмжиж 56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Дараагийн асуудал бол дундын хувилбар л орсон. Бас баахан маргалдаж, маргалдаж 3 хэлэлцүүлэг дамнаж маргалдсан.

7.Төслийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.5 дахь хэсэг нэмэх, “17.5.Улсын Их Хурал энэ хуулийн 17.4-т заасан тогтоол баталсан бол тухайн тогтоолд заасан хугацаанд Засгийн газар тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.” санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.Сүхбаатар гишүүнээ. Санал хураалт явж байна шүү. Цөөхөн гишүүн. 23 гишүүн дэмжиж 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.7 дахь хэсэг нэмэх:

“19.7.Улсын Их Хурал энэ хуулийн 19.2, 19.6-д заасан тайланг хянан хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт холбогдох чиглэл өгөх тогтоол батална. Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнг тухайн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.” санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт 22 гишүүн дэмжиж 56.4 хувийн саналаар нь санал дэмжигдлээ.

9.Төслийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсгийг хасаж, дугаарыг өөрчлөх санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо, санал хуралдаа 23 гишүүн дэмжиж 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 33 дугаар зүйлийн 33.11 дэх хэсгийг хасах санал гаргасан. Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт 28 гишүүн дэмжиж 64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг хасах санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.Санал хураалтад 24 гишүүн дэмжиж, 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12. Тайлбар. Зарчмын зөрүүтэй 11 дэх санал дэмжигдсэн тохиолдолд дараах саналаар санал хураана.

1.Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хасаж, төслийн дугаарыг өөрчлөх санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг үндсэн хууль зөрчсөн гэсэн асуудлаар Улсын Улсын Их Хурлын 8 гишүүн, Үндсэн хуулийн цэцэд орж болно гэсэн заалт гарч байгаа. 25 гишүүн дэмжиж 64.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг буцаах. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт 21 гишүүн дэмжиж 53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. За хууль буцаах санал дэмжигдсэн тул Улсын Улсын Их Хурлын тогтоол уншиж танилцуулъя. Тогтоол батлагдсанд тооцлоо. Хуулийн төсөл буцаах тухай Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь Монгол Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг, Жамбалын Ганбаатар, Сайнхүүгийн Ганбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн, Гонгорын Дамдинням, Лхагвын Мөнхбаатар, Жамъянгийн Мөнхбат, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Нанзаддын Наранбаатар, Салдангийн Одонтуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Ганзоригийн Тэмүүлэн, Баттөмөрийн Энхбаяр нараас 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Улсын

Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн санал дүгнэлт байнгын хорооноос гаргасан, нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай. Төслийн эцсийн найруулгатай саналтай гишүүн байна уу, алга байна. Мөнх-Оргил гишүүн хууль санаачлагч байж өөрөө их юмаа өөрчилсөн юм байна ш дээ. За дараагийнх нь.

1.2 Зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбоотой найруулгын саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.5, 19 дүгээр зүйлийн 19.5, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “Төрийн аудитын” гэсний өмнө “Улсын Их Хурлын Тамгын газар болон” гэж, 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийн “сонсголын тухай” гэсний дараа “болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “хэсэг, түр хорооны” гэснийг “хэсгийн” гэж, 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн “Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах” гэснийг “энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтын “хэлэлцүүлгийн шатны” гэснийг “хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатны” гэж, 23 дугаар зүйлийн гарчгийн “Төсвийн төслийн” гэснийг “Хоёр дахь” гэж, мөн зүйлийн 23.1, 23.4 дэх хэсгийн “Төсвийн төслийн” гэснийг “Хоёр дахь” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “явуулна” гэснийг “явуулж болно” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалтын “дүгнэлт, шаардлагатай бол тогтоолын төсөл боловсруулж” гэснийг “дүгнэлтээ” гэж, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “Цахим нотлох баримтыг бичмэл нотлох баримтад тооцно.” гэснийг “Бичмэл нотлох баримт нь цахим хэлбэртэй байж болно.” гэж, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “томилно. Хянан шалгагч томилох тухай түр хорооны тогтоолд хянан шалгагчийн ажлын даалгавар, шаардлагатай бол ажиллах хугацааг тогтооно.” гэснийг “томилж, ажлын даалгаврыг батална.” гэж, мөн зүйлийн 44.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 44.3.2-т заасны дагуу нотлох баримтыг гаргаж өгөөгүй бол хянан шалгагч энэ хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу нотлох баримтыг цуглуулах тухай тогтоол гаргуулах саналаа түр хороонд гаргана.” гэснийг “Хяналт шалгалтын явцад нотлох баримт гаргуулах шаардлагатай гэж үзвэл хянан шалгагч энэ хуулийн 37.1-д заасны дагуу тогтоол гаргуулах саналаа түр хороонд оруулна.” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “Хянан шалгах түр хорооны сонсголд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хуралдааны явцад дуу, эсхүл дүрсний бичлэг хийх, зураг авахыг хориглоно.” гэснийг “Энэ хуулийн 46.2-т заасан оролцогчид сонсголын явцад дуу, эсхүл дүрсний бичлэг хийх, зураг авахыг хориглоно.” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Улсын Их Хурал хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан /цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх/-тай байна.

5.2.Мэдээллийн нэгдсэн сан нь Улсын Их Хурлаас явуулсан хяналт шалгалтын холбогдох баримт бичиг, мэдээлэл болон хяналт шалгалтын бусад байгууллагаас гаргуулж авсан мэдээлэл, хууль тогтоомжид заасан бусад тогтмол мэдээллээс

бүрдэх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн нэгдсэн сан олон нийтэд нээлттэй байна.”

“30.1.Байнгын хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсгол даргалагчийг сонгох бөгөөд сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална. Сонсгол даргалагч Нийтийн сонсголын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ.”

4.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.3, 25.4 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.3, 28.2.4 дэх заалтын “, түр” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн “, түр хорооны гишүүнийг томилох санал” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. Олон хүн байна. За 64.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

За хамт өргөн мэдүүлсэн Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураа. 2.1.Чуулганы нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөнтэй холбоотой саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт буюу 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг нэмэх. 2/12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг.

“12.4.Нэр дэвшигчийн сонсголд оролцогч гэж энэ хуулийн 10.2-т заасан оролцогчдыг ойлгоно.” санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. Санал хураалтад 39 гишүүн оролцож, 22 гишүүн дэмжиж, 56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 23¹ дүгээр зүйл нэмэх. 3/23¹ дүгээр зүйл.Сонсголын зардал.“23¹ дүгээр зүйл.Сонсголын зардал

23¹.1.Сонсгол зохион байгуулахтай холбогдон гарах аливаа зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.Санал хураалт. 21 гишүүн дэмжиж 53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, төслийн дугаар өөрчлөх:

“3 дугаар зүйл.Нийтийн сонсголын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйл.Үндсэн болон тусгай зарчим:

“3 дугаар зүйл.Үндсэн болон тусгай зарчим

3.1.Нийтийн сонсголыг зохион байгуулахад ардчилсан ёс, хууль дээдлэх, баримт, мэдээлэлд үндэслэсэн байх, талуудын оролцоог тэгш хангах, иргэний мэдэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах, үр нөлөөтэй байх үндсэн зарчмыг удирдлага болгоно.

3.2.Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулахад дараах тусгай зарчмыг баримтална:

- 3.2.1.нэр дэвшигчдэд тэнцвэртэй хандах;
- 3.2.2.нэр дэвшигч, оролцогчдод хүндэтгэлтэй хандах;
- 3.2.3.ил тод, нээлттэй байх.

3.3.Энэ хуулийн 3.2-т заасан тусгай зарчмыг доор дурдсан агуулгаар ойлгоно:

3.3.1.“нэр дэвшигчдэд тэнцвэртэй хандах” гэж нэр дэвшигчийн албан тушаалын болон бусад байдлаас үл хамааран асуултад хариулах, санал хэлэх боломжийг бүх нэр дэвшигчид тэгш олгох бөгөөд аль нэг нэр дэвшигчид давуу байдал олгохгүй байхыг;

3.3.2.“нэр дэвшигч, оролцогчдод хүндэтгэлтэй хандах” гэж албан тушаалын болон бусад байдлаас үл хамааран нэр дэвшигч, оролцогчоос асуулт асуух, үг хэлэхдээ хүндэтгэлтэй хандахыг;

3.3.3.“ил тод, нээлттэй байх” гэж нэр дэвшигчийн сонсголд оролцох хүсэлт гаргасан бол хуулийн үндэслэлгүйгээр татгалзахгүй байх, сонсголыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд, бүрэн дамжуулах, сонсголын тэмдэглэл ил тод байх, оролцогчид тэмдэглэлтэй танилцаж өөрийн саналыг хянах боломжтой байхыг.”

2/10 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсгол:

“10 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсгол

10.1.Энэ хуулийн 6.2.4, 6.2.7, 6.2.8-д заасан сонсголыг нэр дэвшигчийн сонсгол гэх бөгөөд тэдгээрийг зохион байгуулж, явуулахдаа Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай болон холбогдох бусад хуулийг баримтална.

10.2.Нэр дэвшигчийн сонсголд нэр дэвшигч, түүнийг Улсын Их Хуралд танилцуулах эрх бүхий этгээд, эсхүл түүний төлөөлөгч, нэр дэвшигчээс асуулт асуух, нэр дэвшигч нь тухайн албан тушаалд тавигдах шаардлага хангасан эсэх талаар санал хэлэх, мэдээлэл өгөхөөр хүсэлт гаргасан болон хуульд заасны дагуу мэдээлэл өгөх иргэн, хуулийн этгээд, ажиглагч оролцоно.

10.3.Нэр дэвшигчийн сонсголын асуулт, санал болон холбогдох мэдээлэл нь нэр дэвшигчийн мэдлэг, ур чадвар, туршлага, мэргэшил, ёс зүй, хараат бус, бие даан ажиллах чадвар, томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлийн талаар байна.

10.4.Нэр дэвшигчийн сонсголотой холбогдуулан мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, иргэн, хэвлэл, мэдээллийн төлөөлөл оролцох хүсэлт гаргасан бол тэдгээрийг сонсголд заавал оролцуулна.”

3/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:

“12.3.Сонсголыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих талаар хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийг ажиглагч гэнэ. Ажиглагч нь сонсголын үед нэр дэвшигчээс болон бусад оролцогчдоос асуулт асуух, үг хэлэх эрх эдлэхгүй.”

4/15 дугаар зүйл.Сонсголд оролцогчийн эрх, үүрэг:

“15 дугаар зүйл.Сонсголд оролцогчийн эрх, үүрэг

15.1.Сонсголд оролцогч дараах нийтлэг эрх эдэлнэ:

15.1.1.энэ хууль болон холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу асуултад хариулах, тайлбар, санал хэлэх;

15.1.2.сонсголын тэмдэглэл, гарсан шийдвэртэй танилцах, өөрийн хэлсэн санал, тайлбарыг хянах;

15.1.3.сонсгол зохион байгуулагч болон даргалагчаас тэнцвэртэй, хүндэтгэлтэй хандахыг шаардах;

15.1.4.холбогдох бусад хууль тогтоомжид заасан эрх эдлэх.

15.2.Сонсголд оролцогч дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

15.2.1.сонсгол зохион байгуулагчийн дуудсанаар сонсголд хүрэлцэн ирэх;

15.2.2.сонсголын дэг сахих;

15.2.3.сонсгол зохион байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

15.2.4.сонсголд үнэн зөв мэдүүлэх, бодитой дүгнэлт өгөх;

15.2.5.холбогдох бусад хууль тогтоомжид заасан үүрэг хүлээх.

15.3.Сонсголд оролцогч нь сонсголын явцад бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох, яриаг нь таслах, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.

15.4.Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор сонсголыг дохионы хэлмэрчтэй явуулна.

15.5.Сонсгол зохион байгуулагч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонсголд оролцох, ажиглах боломжийг хангана.”

5/17 дугаар зүйл.Сонсгол даргалагч, түүний эрх, үүрэг:

“17 дугаар зүйл.Сонсгол даргалагч, түүний эрх, үүрэг

17.1.Сонсгол даргалагч сонсголыг хуульд заасны дагуу удирдан зохион байгуулах, сонсголын асуудлыг тал бүрээс нь үнэн бодитойгоор тогтоох, сонсголд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх, оролцогчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, сонсголын дэг сахиулах үүрэгтэй.

17.2.Сонсгол даргалагчийг сонгох, томилох асуудлыг энэ хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

17.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлаас зохион байгуулах сонсголын даргалагчийг Байнгын, дэд хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн

олонхын саналаар сонгоно. Сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална.

17.4.Сонсгол даргалагч дараах нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

17.4.1.сонсголын бэлтгэлийг хангах;
17.4.2.сонсголыг товлосон цагт эхлүүлж, дэгийн дагуу явуулах;
17.4.3.сонсголд оролцож байгаа этгээдэд асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх;

17.4.4.сонсголын тайланг хянаж, эрх бүхий этгээдэд танилцуулах;
17.4.5.хүндэтгэн үзэх шалтгаантай оролцогчид чөлөө өгөх;
17.4.6.сонсголын дэг сахиулах, оролцогчдоос дэг сахихыг шаардах;
17.4.7.сонсголын дэг зөрчигчид холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах;

17.4.8.сонсголын асуулт, хариулт, тайлбар, санал, мэдээлэл нь сонсголын сэдэвт хамааралгүй, ялгаварлан гадуурхсан, доромжилсон үг хэллэг хэрэглэсэн бол таслан зогсоох;

17.4.9.сонсголын дэг зөрчсөн, эсхүл энэ хуулийн 15.3-т заасан үйлдэл гаргасан оролцогчид сануулах, зайлшгүй шаардлагатай бол үг хэлэх эрхийг нь хасах;

17.4.10.сонсголын тогтсон сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сануулга өгөх;

17.4.11.сонсголын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг танхимаас гаргах.”

6/18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэг:

“18.8.Сонсгол явуулах талаарх хүсэлт гаргах, тус хүсэлтийг шийдвэрлэх, сонсголын товыг зарлан мэдээлэх, сонсгол зохион байгуулах үйл явц, бүртгэл, сонсголын ирц, үе шат, сонсгол даргалагчийг сонгох, түүний эрх, үүрэг, сонсголын дэг болон сонсголын тэмдэглэл, тайлан гаргахтай холбогдсон харилцааг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон энэ хуулийн 18.7-д заасан журмаар нарийвчлан зохицуулна.” Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. Мөнхсайхан доктороо энийг хэн бичсэн юм бэ? Цэдэвийн Сэргэлэн гишүүн.

Ц.Сэргэлэн: За баярлалаа. Даргаа миний төхөөрөмж ажилласангүй ээ, би уг нь чадлаараа л дарсан юм даа.Тэгэхлээр саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулж өгнө үү гэсэн горимын санал гарч байна.

Г.Занданшатар: Цэдэвийн Сэргэлэн гишүүний горимын саналаар санал хураалт явуулна. Санал хураалт эсрэг гарсан байна гэж байна. Дэгийн тухай хуулийн дагуу Цэдэвийн Сэргэлэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Анандбазар гишүүн суудалдаа суу, санал хураалт явж байна, Санал хураалт. Цогтгэрэл, Батсуурь гишүүн саналаа өгөөрэй. Баттөмөр,

Анандбазар гишүүн, энд байгаа гишүүд ингээд дэмжиж байгаа гэж хэн эсрэг байна. Ундрам, Учрал, Хүрэлбаатар. За Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Би саналыг дэмжиж байгаа юм. Тэгээд дараад үнэхээр аппарат ажилласангүй энэ саналыг хүчингүй болгож өгнө үү.

Г.Занданшатар: За энэ 21 гишүүн болчихоод байна л даа. Байнгын хорооны дарга нь хайчав? Баттөмөр гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 22 гишүүн дэмжиж 56.4 хувийн саналаар Баттөмөр гишүүний горимын санал дэмжигдлээ. Энэ дэгийн хууль, сонсголын хууль дагаад хийчхэж болохоор юмнууд байгаа юм. Ингээд санал хүчингүйд тооцсон учраас дахин санал хураалт явуулъя. Уншсан санал хураалт. Дахин санал хураалт явж байна шүү. Цаашдаа ингэж ийм урт санал бараг хууль бичиж ингэж санал хураадаг дэгийг өөрчлөхгүй бол заримдаа хэтэрч байна шүү. 2,3 хуудсаар нь. 22 гишүүнд дэмжиж 56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 18.9 дэх хэсэг, төслийн 3 дугаар зүйлийн “10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “нийт гишүүний дөрөвний нэгээс” гэснийг “есөөс” гэж,” гэснийг тус тус хасах санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. 5 дугаар саналыг 23 гишүүн дэмжиж, 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “20 дугаар зүйлийн” гэсний өмнө “мөн зүйлийн 18.7 дахь хэсгийн “батална.” гэснийг “баталж болно.” гэж,” гэж нэмэх санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт 23 гишүүн дэмжиж 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төсөлд доор дурдсан агуулга бүхий 5 дугаар зүйл нэмэх.“5 дугаар зүйл.Нийтийн сонсголын тухай хуулийн 11¹ дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.” санал гаргасан. Төрийн байгуулалтын байнгын хороо санал хураалт, за гурван санал хураалт хэлчихсэн байна. 23 гишүүн дэмжиж 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3-т хамт өргөн мэдүүлсэн зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Чуулганы нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулах чиглэл, өгсөнтэй холбоотой саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 15.33 дугаар зүйлийн гарчгийн “15.33 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтад саад учруулах” гэснийг “15.33 дугаар зүйл.Парламентыг үл хүндэтгэх” гэж өөрчлөх.Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалтаа 23 гишүүн дэмжиж 59 хувийн саналаар санал дэмжлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмэх. 6.Энэ зүйлийн 1-5 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан болон Улсын Их Хурлаас зохион байгуулах сонсголд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаан, сонсголд оролцсон этгээд дэг зөрчсөн, санаатайгаар худал мэдээлэл өгсөн, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар албан тушаалтанд оногдуулсан үүргийг хугацаанд нь биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол хүнийг 100- 300 нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр, хуулийн

этгээдийг 2000-4000 нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр торгоно. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.Улсын Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт үг хэлнэ.

С.Бямбацогт: Улсын Улсын Их Хурлын тухай хуулийг бас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулаад 2020 онд шинэчилж найруулж баталсан. Улсын Улсын Их Хурлын тухай хууль дээр бас яг энэ заалт байдаг юм. Улсын Улсын Их Хурлын чуулганы хуралдаан болон Улсын Их Хурлаас зохион байгуулах, Улсын Улсын Их Хурлын чуулганд тийм үү? Хүндэтгэн үзэх шалтгаанаар хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаан сонсголд оролцсон этгээдийг дэг зөрчсөн, санаатайгаар худал мэдээлэл өгсөн бол тийм үү? Мөн Улсын Их Хурлаас өгсөн үүрэг хугацаанд нь биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол гэсэн заалт, энийг хяналт шалгалтын тухай хуульд бас яг энэ агуулгаар нь оруулж байгаа. Тэгээд энийг манай гишүүд ойлгохдоо зүгээр л зөрчлийн хуулиар торгоод өнгөрөх гэж байгаа юм биш үү гэж ойлгодог. Үүнээс гадна бол төрийн албаны тухай хуулиар бас хариуцах, холбогдох албан тушаалтанд хуулийн хариуцлага тооцно.

Цаашлаад нэгэнтээ Төрийн албаны тухай хуулиар хариуцлага тооцох гэсэн бол тэр албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн гээд огцрох асуудал хүртэл яригдана. Ийм үр дагавартай заалтууд байгаа. Мөн шаардлагатай гэж, өшөө ач холбогдолтой гэж үзэх юм бол бас эрүүгийн хуулиар ч хариуцлага хүлээх бололцоотой ийм заалтууд Улсын Улсын Их Хурлын тухай хуульд орсон. Мөн Улсын Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд орж байгаа юм. Улсын Улсын Их Хурлын чуулганы хуралдаан болон Улсын Их Хурлаас зохион байгуулах сонсголд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаан, сонсголд оролцсон этгээд дэг зөрчсөн, санаатайгаар худал мэдээлэл өгсөн, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд холбогдох зүйл, хэсэг, заалтаар албан тушаалтан оногдуулсан үүргийг хугацаанд нь биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол зөрчлийн хуулиар 1-т нь тийм хариуцлага хүлээх нь байна. Дараа нь бол Төрийн албаны тухай хуулийн хариуцлага хүлээнэ.Төрийн албаны хуулиар хариуцлага хүлээсэнтэй холбогдуулаад Үндсэн хууль зөрчсөн асуудал үүсэх, цаад талд нь дахиад эрүүгийн хуулийн хариуцлага хүлээх гэсэн ийм үе шаттай бас санкцууд байгаа. Эндээс зөвхөн зөрчлийн хуультай холбоотой хэсэг нь л энд орж байгаа шүү. Энийг бол манай гишүүд болон бас холбогдох албан тушаалтан бас мэдэж байх ёстой. Ингэж байж парламент хүндэтгэлтэй хандана. Ингэж байж парламент бас хариуцлагатай болно. Үүднээс ийм санкцууд орсон гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Дэмжиж үг хэллээ. Санал хураалт явуулъя. Анхааралтай гишүүд. Санал хураалт 23 гишүүн дэмжиж, 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Чуулганы нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулах чиглэл, өгсөнтэй холбоотой саналын томъёолол: 1. Төслийн 3 дугаар зүйлийн “9 дүгээр зүйлийн” гэсний өмнө “8 дугаар зүйлийн 8.4.3 дахь хэсгийн “байгууллагад” гэснийг “байгууллага, Улсын Их Хуралд” гэж,” гэж нэмэх санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. 23 гишүүн дэмжиж 59 хувийн саналаар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.